ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

GUIDE BOOK















БУУЖ Л ӨГӨХГҮЙ БОЛ
ГАРЦ ЗААВАЛ БАЙДАГ, ЗААВАЛ ШҮҮ.

Японы бизнесмэн, зохион бутээгч,
Тоёота группыг үүсгэн байгуулагч ТОЁОТА САКИЧИ (1867-1930)

Япон улсын Элчин сайдын яам

Япон Улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахыг хүсэж буй Монголын оюутан, залуусыг зориулсан Элчин сайд Х.Кобаяшигийн мэндчилгээ



Элчин сайд
Х.Кобаяши

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Япон Улсад суралцах хүсэлдээ хөтлөгдөн, энэхүү сэтгүүлийг сонирхон уншиж байгаа та бүхэнд баярлалаа.

Та бүхэнд "Япон" гэвэл юу дүрслэгдэж байна вэ? Монголд японы анимэ, автомашин нэлээд нэртэй хэдий ч Японд та бүхний сонирхлыг татах зүйлс эдгээрээс хавьгүй их байгаа гэж бодож байна. Энэхүү сэтгүүлийг заавал уншиж, Японд суралцах талаар болоод өөрийнхөө ирээдүйн мөрөөдлийг биелүүлэх төсөөллийг хийгээсэй хэмээн хүсэж байна.

Японы их сургуульд ямар ч мэргэжлээр суралцсан шилдэг багш, профессорууд өндөр түвшний сургалтыг явуулах орчин бүрдсэн байгаа болов уу. Мөн Японд суралцсанаар мэдлэг, боловсролыг олж авах төдийгүй япон хэл сурч, тухайн орчинд амьдарснаар Японы соёлыг өөрийн биеэр үзэж, тухайн нийгмийг ойлгох чухал боломж гарч ирэх юм. Түүнчлэн дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн гадаад оюутнуудтай хамт суралцаж, янз бүрийн үзэл бодолтой хүмүүстэй уулзаж, олон орны соёлыг мэдэрч, өөрийн харах өнцгийг өргөжүүлэн, тухайн улс орны онцлог, тулгамдаж буй асуудлуудын талаар олж мэдэж чадах болов уу. Японд суралцах боломж нь та бүхний хүсэл мөрөөдөл, зорилгыг биелүүлэхэд анхны тань алхам болж, улмаар амьдралаа илүү үр бүтээлтэй сайхан болгож чадна гэдэгт бат итгэлтэй байна.

Тус сэтгүүлд Япон Улсын Засгийн газрын тэтгэлгээр суралцаад одоо Монголд амжилттай ажиллаж буй залуусын ярилцлага, зөвлөгөө нэлээд байгаа. Японд суралцсан туршлагатай залуус өөрсдийн олж авсан мэдлэг, хэлний чадвар, танил талын хүрээгээ ашиглан, компани байгуулж амжилттай үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгч, улс төрч, их сургуулийн багш, дизайнер, орчуулагч, дуучин гэх мэт олон салбарт одоогийн Монголын нийгмийг авч явж буй чадварлаг боловсон хүчин болон ажиллаж байна.

Та бүхэн Япон Улсад суралцсан үе үеийн төгсөгчдийг залгамжлан Монголын ирээдүйг авч явах боловсон хүчин болохыг чин сэтгэлээсээ хүсэж байна.

Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц
бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
Кобаяши Хироюки



Шөнийн Токио хот

ДУГААРЫН ХӨТӨЧ

3 ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРӨӨР СУРАЛЦАХ БОЛОМЖТОЙ ТОП СУРГУУЛИУД

5 ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРӨӨР ЯПОНД СУРЦГААЯ

8 ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ ХАРИУЛТ

9 ЯПОНД ТӨГСӨГЧДИЙН СЭТГЭГДЭЛ

10 ЯПОНЫ ИХ СУРГУУЛЬ, ТЭТГЭЛГИЙН МЭДЭЭЛЭЛ АВАХ СОШИАЛ ЦАХИМ ХУУДСУУД

11 ЯПОНД ТӨГСӨГЧИД ЯРЬЖ БАЙНА ЯРИЛЦЛАГА

16 ЖУГАМО НИЙГЭМЛЭГ

17 ЯПОН ДАХЬ МОНГОЛ ОЮУТНЫ ХОЛБОО

18 ЯПОН ОРНЫ ТУХАЙ СОНИРХОЛТОЙ МЭДЭЭЛЭЛ

ЯПОН УЛСЫН ЗАСТИЙН ГАЗРЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРӨӨР СУРАЛЦАХ БОЛОМЖТОЙ ТОП ИХ СУРГУУЛИУД



ТОП 30 СУРГУУЛЬ

Японы төгсөх ангийн 90 мянга гаруй сурагчаас авсан судалгааны үр дүнг хураэж байна. ТОП нэгт Токиогийн их сургууль шалгарсан бол мужийн их сургуулийн нэгт "Нагоя" их сургууль оржээ. Хувийн их сургуулийн хувьд "Аояама" Гакуины их сургууль орсные JS corporation – ийн судалгаанд дурьдсан байна.
/ https://www.js-corp.co.jp/corp/info/ 2020/04/15 судалгаа

Улсын их сургууль
1-р байрт "Токиогийн их сургууль"
2-р байрт "Цукубагийн их сургууль"
3-р байрт "Осака их сургууль" "Нагоягийн их сургууль"
5-р байрт "Кёотогийн их сургууль"
6-р байрт "Тохоку их сургууль" "Хоккайдогийн их сургууль"
8-р байрт "Чибагийн их сургууль"
9-р байрт "Шизуокагийн их сургууль"
10-р байрт "Рюкюгийн их сургууль"

Мужийн их сургууль
1-р байрт "Нагоя хотын их сургууль"
2-р байрт "Токио Метрополитаны их сургууль"
3-р байрт "Осака Сити их сургууль"
4-р байрт "Айчи мужийн их сургууль"
5-р байрт "Мэйо их сургууль"
6-р байрт "Осака мужийн их сургууль"
7-р байрт "Шизуока мужийн их сургууль"
8-р байрт "Ёкохама хотын их сургууль"
9-р байрт "Акита олон улсын их сургууль"
10-р байрт "Иватэ мужийн их сургууль"

Хувийн их сургууль
1-р байрт "Аояама Гакуины их сургууль"
2-р байрт "Кинкийн их сургууль"
3-р байрт "Мэйжигийн их сургууль"
4-р байрт "Keio University"
5-р байрт "Кансай их сургууль"
6-р байрт "Васедагийн их сургууль"
7-р байрт "Рицумейкан их сургууль"
8-р байрт "Дошишагийн их сургууль"
9-р байрт "Мэйжогийн их сургууль"
10-р байрт "София их сургууль"

Эх сурвалж:
www.js-corp.co.jp



1 ТОКИО их сургууль

Япон улсдаа нэгдүгээрт Токиогийн их сургууль (The University of Tokyo) бичигддэг. Уг сургууль нь 1877 онд байгуулагдсан, Япон улсын эртний сургуулиас 15 Ерөнхий сайд, таван сансрын нисгэгч, дэлхийд алдартай эрдэмтэн судлаач олноор төрөн гарчээ. Дэлхийд 24 дугаарт жагсдаг сургуульд 28.000 гаруй залуус суралцаж байна.



2 КЁОТО их сургууль

Нэрт судлаачид болон Нобелийн 13 шагналаараа алдаршсан Кёотогийн их сургууль (Kyoto University) нь дэлхийн топ сургуулиудын 38 дугаарт жагсдаг. Харин улсдаа хоёрдугаарт эрэмблэгддэг. Тус сургууль нь 1897 онд байгуулагдсан бөгөөд техник технологи, шинжлэх ухааны салбарт тэргүүлэгч сургууль юм.



3 ОСАКА их сургууль

Осакагийн их сургууль (Osaka University) нь 1931 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Японы эртний зургаан сургуулийн нэг юм. 2018 онд шүд, химийн инженерчлэл, физик, одон орон, байгалийн ухааны чиглэлээр Дэлхийн шилдэг 50 сургуульд багтсан. 72 дугаар байрт эрэмбэлэгдсэн.



5 ТОХОКУ их сургууль

Тохокүгийн их сургууль (Tohoku University) 1907 онд үүсгэн байгуулагдсан. Онцлог нь эмэгтэйчүүд, олон улсын оюутан суралцахыг зөвшөөрсөн анхны сургууль юм. 2019 оны байдлаар тус сургууль дэлхийд 79 дугаарт эрэмбэлэгдэж байна. Харин улсдаа тавт жагсдаг. Инженхдээ их сургуулиудын арван шалгуур үзүүлэлээс хамгийн өндөр оноог авсан аж.

Топ сургуулийн жагсаалт 2021
Эх сурвалж: www.topuniversities.com

ЗАЛУУСТ ХҮРГЭХ ЗАХИДАЛ

ТОКИОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ТӨГСӨГЧ

Би их олон сургуульд сурсан. Тэр дундаас Токиогийн их сургууль их амбиц өндөртэй, судалгааны төсөв мөнгийг ч хангалттай өгч чаддаг. Оюутнуудын хувьд ч "бид нар дэлхийг өөрчилнө" гэсэн үзэл бодол, омогшилтой суралцдаг.

p.11



С.ЭНХБАЯР

КЁОТОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ТӨГСӨГЧ

Би Токиогийн их сургуулийг магистр, Кёотогийн их сургуулийг докторооор хамгаалсан. Кёотогийн их сургуулиас Нобелийн шагналтан олноор төрсөн. Дэлхийн топ судалгаанууд хийгддэг. Хүмүүсийн харилцаа нь найрсаг, тусч байдаг. Японы уламжлалт түүхийг бодитоор хадгалсан үзэсгэлэнт хотод байрладаг. Япон соёлыг орчинд нь сурьяа гэвэл Кёотогийн их сургуулийг сонгох нь зөв.

p.11



Д.Амаржаргал

p.11

Нагояагийн их сургуулийн хувьд оюутан, багш, судлаачийн үзэл бодол санаачлагыг их дэмждэг, сонсдог, чөлөөт сэтгэлгээтэй сургууль гэж боддог. Ялангуяа гадаад оюутнууд суралцахад илүү тохиромжтой. Тийм учраас магадгүй олон Нобелийн шагналтнууд төрөн гарсан бизээ.



Л. Анхбаяр



6 НАГОЯА их сургууль

Нагоягийн их сургууль (Nagoya University) нь 1939 онд үүсгэн байгуулагдсан. XXI зууны эхэн үед Нобелийн шагнал хүртсэн шагналтнуудын гуравны хоёр нь тус сургуулийнх юм. Дэлхийн 110 дүгээрт эрэмблэгддэг тус сургууль "Чөлөөт нээлттэй" академик хэв маягийн уламжлалттай. Дэлхийн өнцөг булан бүрээс хүний нөөцийг цуглуулж, оюутан, судлаач өдөр бүр бие биетэйгээ харилцах боломжтой англи хэлний кампусын орчинг бүрдүүлсэн байдаг.



ХИРОШИМА их сургууль 14

1949 онд байгуулагдсан Япон улсдаа 14 дүгээрт жагсдаг шилдэг сургуулиудын нэг. Япон улсын "Топ глобал их сургууль" хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Тус сургууль (Hiroshima University) бакалаврын зэрэгт суралцаж буй оюутнуудын чадварыг дээшлүүлэх зорилгоор суралцагч тус бүрт тохирсон боловсролын системийг хэрэгжүүлдэг онцлогтой.



7 ХОККАЙДО их сургууль

Газар зүйн байршлаараа Япон улсын хамгийн хойд хэсэгт, сэрүүн хэсэгт байрладаг. Хоккайдогийн их сургууль (Hokkaido University) улсдаа долоодугаарт жагсдаг.1876 онд Япон улсын анхны бакалаврын зэрэг олгох байгууллага болон байгуулагдаж байжээ. Дэлхийд 139 дугаарт эрэмблэгддэг. Хөдөө аж ахуйн салбарын судалгаа, лаборатори, сургалтаараа алдартай.



ХИТОЦҮ БАШИ их сургууль 20

Мори Аринори тус сургуулийг 1875 онд нээжээ. Тус сургууль нь арилжааны сургалтын сургуулиас гаралтай. Японы хамгийн эртний нийгмийн шинжлэх ухааны их сургууль юм. Дэлхийн топ их сургуулиудтай хамтран ажилладаг ба 49 орны 800 гаруй гадаад оюутан суралцаг. Канад, Франц, Герман, Итали, Япон, АНУ, Европын холбооны улс хамтарсан "University-7" холбооны гишүүн сургууль гэдгээрээ алдартай.



8 КЮҮШЮҮ их сургууль

1903 онд байгуулагдсан Кюүшюүгийн их сургууль (Kyushu University) нь Япон улсын дөрөв дэх эртний сургууль юм. Газар зүйн байршлаар хамгийн урд хэсэгт байрладаг.Чийгэлэг дулаан уур амьсгалтай. Бүх шатандаа шилдэг, Дэлхийн хэмжээний боловсрол олгогч гэдгээрээ алдартай. Уг сургууль нь 2021 онд Дэлхийд 124 дугаарт жагссан юм. Шинжлэх ухааны дээд сургуулийн профессор Косуке Моритагаар ахлуулсан судалгааны баг 113 дугаар элементийг "nihonium (Nh)" нээж илэрүүлсэн нь Азид анхных юм.



27 САЙТАМА их сургууль

1949 онд байгуулагдсан тус сургууль улсдаа 27 дугаарт эрэмблэгддэг. "Зүүн азийн бүс нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих" хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлдэг. Хүрээлэн буй орчин, сансар, амьд биет судлалын судалгааны төвөөрөө алдартай.

Топ сургуулийн жагсаалт 2021
Эх сурвалж: www.topuniversities.com

ТЕХНИКИЙН ТОП КОЛЛЕЖУУД

Япон улсын сургалтын системд нэгэн онцлог сургууль бий. Тэр нь ерөнхий боловсролын ахлах ангиас элсэн суралцах боломжтой "Техникийн коллеж" буюу "КООСЭН" сургууль юм. Тус сургуулийг өнөөдрийн үсрэнгүй хөгжилтэй, өндөр технологийн Японыг бий болгоход асар том нөлөө үзүүлсэн гэж үздэг. Японы хүнд, хөнгөн үйлдвэр, техник технологи, шинжлэх ухааны салбарын үндсэн мэргэжилтэн, инженерийг 17 наснаас нь үйлдвэрийн дадлага, лабораторийн туршилтад суралцуулж, бэлддэг.

Салбар, салбарын шилдгийн шилдэг "КООСЭН" – техникийн коллежуудыг танилцуулж байна.

SCAN ME

TOKYO COLLEGE OF AUTOMOBILE INSTITUTE

ЭЛЕКТРОН, ЦАХИЛГААНЫ САЛБАР





NIHON KOGAKUIN

КОМПЬЮТЕР, IT, ВЭБ, ТОГЛООМЫН САЛБАР



SCAN ME

SCAN ME

JAPAN AVIATION COLLEGE

АВТОМАШИН, НИСЭХИЙН САЛБАР



JAPAN HOTEL SCHOOL

ЗОЧИД БУУДАЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР



SCAN ME

Эх сурвалж: www.senmongakkou-ranking.info



ЗАЛУУСТ ХҮРГЭХ МЭССЭЖ

ЯАГААД ЗААВАЛ КООСЭН ГЭЖ ?

Нэгдүгээрт, дунд сургуулиа төгсөөд "Коосэн" буюу техникийн сургуульд суралцах боломжтой. Ахлах сургуулийн мэдлэгтэй хослуулан лабораторийн орчинд мэргэжлийн хичээл үздэг. Өөрөөр хэлбэл, их сургуулийн II курст суралцах насан дээрээ техникийн коллежоо төгсөөд ажлын байранд очно. Коосэний практик дадлага сайн болохоор төгсөөд их сургуульд элсэх, ажлын талбарт гарахад хялбар байдаг. Жишээ нь, Японы үндэсний хэмжээний корпорациуд (Тоёота, Хитачи, Шисэйдо гэх мэт) өөрийн лаборатори, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хэлтэстээ их сургуулийн төгсөгчөөс илүүтэй "коосэн" (мэргэжлийн сургууль) төгсөгчдийг чухалчлан үздэг. Коосэн төгссөн оюутан, их сургуульд суралцвал ажлын байрны үнэлэмж улам өндөр болдог. Миний сурсан Окинавагийн Коосэн коллежийн хувьд дулаан уур амьсалтай амьдрахад таатай газар байдаг. АНУ–ын цэргийн бааз байдаг болохоор англи хэлээр ярилцах, амьдрах боломжтой байсан.

Б. Билэгсайхан

Япон улсын Засгийн газрын ТЭТГЭЛГЭЭР СУРАЛЦАЯ!

Өөрт тохирох хөтөлбөрийг хайж олцгооё

Хөтөлбөрт хэрхэн хамрагдах вэ

Ямар чиглэлээр суралцахыг хүсэж байна

Эрдмийн зэрэг хэрэгтэй эсэх

Тэтгэлэгийн хэмжээ

	Судлаач оюутан	Их сургуулийн үндсэн оюутан	Технологийн коллежийн оюутан	Мэргэжлийн сургуулийн оюутан
Нас, Хамрагдах боломжтой суралцагч	35 хүртлэх насны 16 жилийн боловсрол эзэмшсэн Эрдмийн зэрэг (Бакалавр)	17—25 насны 12 жилээс дээш боловсрол эзэмшсэн байх	25 хүртлэх насны 12 жилээс дээш боловсрол эзэмшсэн байх	25 хүртлэх насны 12 жилээс дээш боловсрол эзэмшсэн байх
Эзэмших эрдмийн зэрэг	Магистр, доктор зэрэгтэй бол эрдмийн зэрэг ахихгүй	Бакалавр	Хоёр жил нэмж суралцвал бакалаврын зэрэг эзэмших боломжтой	Байхгүй
Япон хэлний бэлтгэл	Шаардлагатай бол зургаан сар	Нэг жил	Нэг жил	Нэг жил
Суралцах хугацаа	Хоёр жил. Магистр, доктор, мэргэжлийн зэрэг олгох сургалтад дэвшин суралцсан суралцагч нь шалгуур тэнцсэн тохиолдолд виз сунгагдах боломжтой	Тав жил. (Япон хэлний бэлтгэл нэг жил + бакалаврын зэрэг дөрвөн жил.) • Эмч, шүдний эмч, малын эмч—зургаан жил. Сургуулиа төгссөний дараа магистрын албан ёсны сургалт руу дэвшин суралцах боломжтой.	Дөрвөн жил (Япон хэлний бэлтгэл нэг жил+ суралцах хугацаа гурван жил)	Япон хэлний бэлтгэл нэг жил+ суралцах хугацаа хоёр жил
Суралцсаны дараах үе шат	Магистр болон докторт дэвшин суралцах боломжтой. • Нөхцөөсөө хамаараад, албан бус сургалтаас албан ёсны сургалт руу элсэх боломжтой.	Нэг жил Япон хэлний бэлтгэл—сонгосон салбар сургуульдаа дэвшин суралцах	Япон хэлний бэлтгэл нэг жил, Технологийн коллеж гурван жил суралцана. Үргэлжлүүлэн суралцах боломжтой.	Япон хэлний бэлтгэл нэг жил Коллежид хоёр жил Их сургуульд гурван жил суралцах боломжтой
Япон улсад суралцаж эхлэх хугацаа	Дөрөвдүгээр сар эсвэл аравдугаар сар	Дөрөвдүгээр сар Шууд хамрагдах бол дөрөв, ес, эсвэл аравдугаар сар	Дөрөвдүгээр сар	Дөрөвдүгээр сар
Тэтгэлэгийн хэмжээ	Бэлтгэл сургууль ба албан бус сургалтын сурагч: 143.000 иен (сард) Магистр, мэргэжлийн зэргийн сургалт: 144.000 иен (сард) Докторантур: 145.000 иен (сард)	Сар бүр 117.000 иен	Сар бүр 117.000 иен	Сар бүр 117.000 иен
Тэтгэлэг олгогдох хугацаа	Дөрөвдүгээр сард Японд ирнэ. Дөрөвдүгээр сарын элсэлт Японд ирсэн оныхоо Дөрөвдүгээр сараас хоёр жил, гуравдугаар сар хүртэл Аравдугаар сард Японд ирнэ. Японд ирсэн оныхоо ес эсвэл аравдугаар сараас хоёр жил, гуравдугаар сар хүртэл (Албан ёсны) Тус тусын сургалтын хугацаа	Хэлний бэлтгэлээс их сургууль төгсөх хүртэл таван жилийн хугацаанд олгоно. (Эмч, шүдний эмч, малын эмч—долоо, их сургууль дөрвөн жил)	Суралцаж эхлэх хугацаанаас төгсөх хүртэл олгогдоно. Дөрвөн жил	Суралцаж эхлэх хугацаанаас төгсөх хүртэл олгогдоно. Гурван жил
Сургалтын зардал	Сургалтын зардлыг Боловсролын яам хариуцна. Харин албан ёсны оюутнаар дэвшин суралцахгүй, эсвэл шалгалтад тэнцээгүй бол, элсэлтийн шалгалтын хураамжаа өөрөө төлнө.	Сургалтын зардлыг Боловсролын яам хариуцна.	Сургалтын зардлыг Боловсролын яам хариуцна.	Сургалтын зардлыг Боловсролын яам хариуцна.
Онгоцны зардал	Тогтсон дүрэм журмын дагуу явах бол Боловсролын яам хариуцна.	Тогтсон дүрэм журмын дагуу явах бол Боловсролын яам хариуцна.	Тогтсон дүрэм журмын дагуу явах бол Боловсролын яам хариуцна.	Тогтсон дүрэм журмын дагуу явах бол Боловсролын яам хариуцна.
Гэр бүлийн хувьд	Гэр бүл (нөхөр, эхнэр) болон хүүхдийн онгоцны зардал, амьжиргаа болон эрүүл мэндийн зардлыг Боловсролын яам хариуцахгүй.	Гэр бүл (нөхөр, эхнэр) болон хүүхдийн онгоцны зардал, амьжиргаа болон эрүүл мэндийн зардлыг Боловсролын яам хариуцахгүй.	Гэр бүл (нөхөр, эхнэр) болон хүүхдийн онгоцны зардал, амьжиргаа болон эрүүл мэндийн зардлыг Боловсролын яам хариуцахгүй.	Гэр бүл (нөхөр, эхнэр) болон хүүхдийн онгоцны зардал, амьжиргаа болон эрүүл мэндийн зардлыг Боловсролын яам хариуцахгүй.
Их сургуульд элсэх	Элсэхийг хүсч буй их сургуулийнхаа "Элсэх зөвшөөрөл"—ийг хавсаргах ба их сургуулийн хяналтаар шийдвэрлэнэ.	Хэлний бэлтгэлийн сурлага, тухайн хүний элсэхийг хүсч буй дээд сургууль, мэргэжил зэргийг харгалзан үзэж шийдвэрлэнэ.	Тухайн хүний суралцах хүсэлтэй мэргэжлийн салбарыг харгалзан шийдвэрлэнэ.	Тухайн хүний суралцах хүсэлтэй мэргэжлийн салбарыг харгалзан шийдвэрлэнэ.
Япон улсын ЗГ, улсын зардлаар суралцах бусад тэтгэлэгт хөтөлбөрт давхар хамрагдах боломжтой эсэх	үгүй	үгүй	үгүй	үгүй
Анхаарах зүйл (Голч дүн/оноо 3.5—аас дээш байх)	Өмнө нь Засгийн газрын тэтгэлэгт оюутан байсан бол буцаж ирсэнээс хойш гурван жил ажилласан, судалгаа хийсэн байх. Судалгаа хийх чиглэлээр удирдах багш байгаа эсэхийг өөрөө шалгах. Оюутны дотуур байргүй их сургууль байх тохиолдол бий.	Өмнө нь засгийн газрын тэтгэлэгт оюутан байсан бол хамрагдах боломжгүй. Зөвхөн улсын их сургуульд хамрагдах боломжтой.	Өмнө нь Засгийн газрын тэтгэлэгт оюутан байсан бол хамрагдах боломжгүй. Технологийн коллеж бол их сургууль биш юм. Эмэгтэй оюутан хүлээж авах дотуур байр цөөн.	Өмнө нь Засгийн газрын тэтгэлэгт оюутан байсан бол хамрагдах боломжгүй. Коллеж нь их сургууль биш Бакалаврын зэрэг авах боломжгүй.

Хөтөлбөрийн дэлгэрэнгүйг дараагийн хуудаснаас уншаарай...

Япон улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ

Зарлагдах хугацаа (Дөрөвдүгээр сарын сүүл Тавдугаар сарын эх)

Бүртгэлийн хугацаа (5 ӨДӨР)

БҮРТГҮҮЛЭГЧИД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

- *Монгол Улсын иргэн байх*
- *Өмнө нь Япон улсын Засгийн газрын тэтгэлгээр суралцаж байсан бол эргэж ирснээс хойш доод тал нь гурван жилийн хугацаанд судалгааны ажил хийсэн эсвэл ажилласан байх*
- *Тухайн үед Японд хувийн зардлаар суралцаагүй, эсвэл суралцах нь тодорхой болоогүй байх*
- *Бусад байгууллага, эсвэл Монгол Улсын Засгийн газраас тэтгэлэг авааагүй буюу авах нь тодорхой болоогүй байх*



ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР ЯМАР АШИГТАЙ ВЭ

Японы улсын Засгийн газраас дараах тэтгэлгийг олгоно

- *Сургалтын зардлыг 100 хувь хариуцана*
- *Японд суралцах хугацаанд сар бүр тэтгэлэг олгоно*
  - *Их сургуулийн үндсэн оюутан*
  - *Техникийн коллеж*
  - *Мэргэжлийн сургуулийн оюутан*

  > 117.000 иен (тус бүр)
  - *Судлаач оюутан* 143.000 иен
- *Хоёр талын онгоцны тийзийн зардлыг хариуцана*



СУДЛААЧ ОЮУТАН

☐ Японы их сургуульд "Кэнкюүсэй" буюу судлаач оюутан гэсэн статустайгаар 1–2 жил суралцана.

☐ Элсэлтийн шалгалт өгч магистр буюу докторын курст дэвшин Засгийн газрын тэтгэлэгтэйгээр суралцах боломжтой.

Тавигдах шаардлага:

☐ Их сургуулиа төгссөнөөс хойш хоёроос дээш жил ажилласан, эсвэл их сургуулиа төгсөөд магистрантур буюу докторантурт суралцаж байгаа

☐ 35–аас доош насны;
Сүүлд төгссөн их, дээд сургуулийн голч дүн 3.5 буюу түүнээс дээш байх

Өгөх шалгалт

Англи хэл
Япон хэл

ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН ОЮУТАН

☐ *Японы их, дээд сургуульд үндсэн оюутнаар дөрвөн жил суралцаж бакалаврын зэрэгтэй төгсөнө.*


☐ *Анагаах ухаан, шүд, мал эмнэлэг, эм зүйн чиглэлээр зургаан жил суралцана.*

Өгөх шалгалт:

☐ **Их сургуулийн нийгмийн ухааны чиглэл:**
Математик
Англи хэл
Япон хэл

☐ **Байгалийн ухааны чиглэл бол:**
Математик,
Хими
Англи хэл
Япон хэл
Физик эсвэл биологи

(Анагаах ухаан, шүд судлал, хөдөө аж ахуй, мал аж ахуй, мал эмнэлэг, ой судлал, хүнс судлал, эм зүй, эрүүл мэнд, сувилахуйн ухаан зэрэг салбарынхан биологийн шалгалт өгөөрэй)



SCAN ME

КООСЭН БУЮУ ТЕХНИКИЙН КОЛЛЕЖИЙН ОЮУТАН

Техникийн коллежийн хөтөлбөр нь техниктэй холбоотой мэргэжлээр суралцуулж, цаашид ажил эрхлэхэд шаардагдах мэдлэг чадвар эзэмшүүлнэ.

SCAN ME

Элсэлт авах салбар

Механик	*Мэдээлэл, харилцаа холбоо*
Цахилгаан	*Барилга*
Электроник	*Зам гүүр*
Архитектур	*Хөлөг онгоц*

Инженерээр ажиллах хүсэлтэй оюутнуудад тохиромжтой

Өгөх шалгалт:

Бодис материалын салбарт суралцах бол:
Математик
Хими
Англи хэл
Япон хэл

Өгөх шалгалт:

Бусад салбарт суралцах бол:
Математик
Япон хэл
Англи хэл
Физик

Суралцах хугацаа

Үндсэн сургуульдаа суралцах хугацаа гурван жил.
Техникийн коллежийг төгсөөд шалгалт өгч их сургуулийн III курст орох боломжтой.
Ямар чиглэлээр суралцах боломжтой талаар дэлгэрэнгүй мэдээллийг Японы Элчин сайдын яамны вэб хуудаснаас авна уу.

Би Японд дөрвөн сургуульд суралцсан. Эхлээд Осака хотын "Япон хэлний боловсролын төв" хэлний бэлтгэл сургуульд нэг жил суралцсан. Хэлний сургуулийн онцлог нь бүгд гадаад оюутан болохоор Японы талаар олон зүйлийн тухай ярилцаж судалдаг.

Хоёрт, Мэргэжлийн сургуульд (Коллеж) хоёр жил сурсан. Энэ сургуулийн онцлог нь заавал дээд боловсрол эзэмших шаардлагагүйгээр сургуулиа төгсөөд шууд ажлын байранд гарах боломжтой. Мөн онолоос илүү практик мэдлэгт түлхүү анхаардаг.

Гуравт, Осакагийн үйлдвэрлэлийн их сургуульд орсон. Энэ сургуульд ороход их хялбар байсан. Төлбөрийн хувьд ч гадаад оюутан 50 хувь хөнгөлөлттэй байсан.

Дөрөвт, Кёотогийн их сургуульд суралцсан. Уг сургууль Японы уламжлалт түүхээ бодитоор хадгалсан үзэсгэлэнт хотод байрладаг. Японд соёлыг орчинд нь суръя гэвэл гоё сургууль.



Д.Мөнхбат

МЭРГЭЖЛИЙН СУРГУУЛИЙН ОЮУТАН

Мэргэжлийн сургууль нь ажлын болон техникийн практик боловсролыг олгодог сургууль юм.

Элсэлт авах салбар

Технологи	*Бизнес*
Хүнсний тэжээл судлал	*Загвар зохион бүтээх*
Боловсрол ба нийгмийн халамж	*Тогооч*
Оёдол зэрэг салбар багтдаг.	

Нэг жилийн бэлтгэлээс гадна хоёр жил үндсэн сургуульдаа суралцана.

SCAN ME

Өгөх шалгалт:

Математик
Англи хэл
Япон хэл

Мэргэжлийн сургууль нь их сургуулийн адил бакалаврын зэрэг олгодоггүй ч маш олон мэргэжлийн чиглэлээр мэргэшин суралцах боломжтой. Сургуулиа төгсөөд их сургуулийн шалгалт өгч III курсээс үргэлжлүүлэн сурах боломжтой.

Дээрх дөрвөн чиглэлээр шалгалт өгөхөөр бүртгүүлэхдээ тодорхой материалыг бүрдүүлэх шаардлагатай байдаг. Тус мэдээллийг ЭСЯ-ны вэб хуудаснаас авах боломжтой. Мөн бүрдүүлэх материалын жагсаалтад өөрчлөлт орох магадлалтай тул тухайн жилийн шалгалтын зар, мэдээллийг анхааралтай уншиж байхыг зөвлөж байна.

Ямар чиглэлээр суралцах боломжтой талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Японы Элчин сайдын яамны вэб хуудаснаас авна уу.

ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Q. Япон хэл огт мэдэхгүй хүн тус шалгалтыг өгөх боломжтой юу?

A. Боломжтой. Шалгалтын материал япон болон англи хэл дээр учир аль нэгийг сонгох боломжтой. Япон хэлний анхан шатны мэдлэгтэй байх нь танд давуу тал болно. Харин хэлний шалгалтын хувьд япон, англи хэлний шалгалтын аль өндөр оноо авсныг тооцдог.

Q. Ямар хүмүүс шалгалтын бүртгэлд хамрагдах боломжгүй вэ?

A. Шалгалтын бүртгэлд хамрагдах боломжгүй нөхцөлүүдийг танилцуулъя. Үүнд:

- Шалгуулагчдад тавьж буй болзол, шалгууруудыг хангаагүй;
- Цэргийн албан хаагч бол;
- Өмнө нь Япон улсын Засгийн газрын тэтгэлгээр суралцаж төгссөнөөс хойш гурван жилийн хугацаанд ажил эрхлээгүй эсвэл их сургуульд суралцаагүй хүн;
- Одоо Японы их, дээд сургуульд суралцаж байгаа хүн;
- Бусад байгууллагын болоод Засгийн газрын тэтгэлэгт хамрагдаж байгаа хүн;
- Шалгалтад тэнцсэн ч заасан хугацаанд Японд очих боломжгүй зэрэг нөхцөлүүд байгаа.
- Дэлгэрэнгүй мэдээллийг ЭСЯ—ны цахим хуудаст шалгалтын зар тавигдах үед авна уу.

Q. Японы Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн шалгалтыг хэдэн удаа өгөх боломжтой вэ?

A. Их сургуулийн үндсэн, техникийн коллеж, мэргэжлийн сургуулийн оюутнаар суралцах хүмүүсийн хувьд Японы Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн шалгалтыг ерөнхий боловсролын сургууль төгсөх ангиас эхлээд их сургуулийн II курс хүртэл нийт гурван удаа өгөх боломжтой. Судлаач оюутнаар суралцах хүмүүс тухайн жилийн шалгалтын болзлыг ханган, заасан насны хязгаарт багтаж байвал шалгалтад жил дараалан хамрагдах боломжтой.

Q. Шалгалтад хэрхэн бэлтгэх вэ?

A. Японы Засгийн газрын тэтгэлэгээр суралцах хүсэлтэй бол их сургуулийн үндсэн, "Коосэн" буюу Техникийн коллеж, Мэргэжлийн сургуулийн оюутан гэх гурван чиглэлийн аль нь өөрт тохирч байгаа, ямар сургуульд орж, ямар мэргэжил сонгохоо шийдэх нь зүйтэй. Судлаач оюутны хувьд ч ямар сургуульд, ямар чиглэл буюу сэдвээр судалгаа хийх, цаашид магистрантур/докторантурт дэвшин суралцах эсэхээ шийдсэн байвал зохино. Мөн өмнөх жилүүдийн шалгалтын материалтай https://www.studyinjapan.go.jp/en/planning/scholarship/application/examination/ хаягаар орж, ирж болзошгүй асуулт, хэлбэр, үг хэллэгийн талаар ойлголт авах боломжтой.


Q. Японд очсон хойно хичээл ямар хэлээр ордог вэ?

A. Их сургуулийн үндсэн, Техникийн коллеж, Мэргэжлийн сургуулийн оюутнуудын хувьд хичээл нь япон хэлээр явагддаг. Мэргэжлээрээ суралцахаас өмнө Токио болон Осака хотын өндөр түвшний япон хэлний сургалтын төвд Японы хэлний бэлтгэлд нэг жил суралцах шаардлагатай. Судлаач оюутнуудын хувьд сургуулиасаа хамааралд англи хэл дээр шууд суралцах боломжтой байдаг.

Q. Японы Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт жилд хэдэн оюутан тэнцэж тус улсыг зорьдог вэ?

A. Японы Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг олон улс оронд нэгэн зэрэг зохион байгуулдаг. Улмаар эцсийн дүнгээс хамааран тухайн орноос тэнцэн Японыг зорих оюутны тоо өөр өөр.
Хөтөлбөрийн 2020 оны шалгаруулалтад тэнцэж Японд суралцах болсон оюутны тоог танилцуулахад:

- Их сургуулийн үндсэн оюутан — 8
- Коосэн/Техникийн коллежийн оюутан — 18
- Мэргэжлийн сургуулийн оюутан — 6
- Судлаач оюутан — 12.



Q. Японд суралцахдаа гэр бүлээ авч явж болох уу?

A. Суралцах хугацаандаа өөрийн гэр бүлийн хүн, төрсөн үр хүүхдээ Японд урин хамт амьдрах боломжтой. Ингэхдээ юуны түрүүнд өөрийн сурч буй суургуулиасаа зөвшөөрөл авах бөгөөд очих, ирэх нисэх онгоцны тийз, Японд амьдрахад шаардагдах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцана.

Q. Гадаадад байгаа Монгол Улсын иргэн Японы Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн шалгалт өгч болох уу?

A. Болно. Бүртгэлийг Улаанбаатарт буй ойрын хүмүүсээр дамжуулан хийлгэх боломжтой. Харин бичгийн болон ярилцлагын шалгалтаа заавал өөрийн биеэр ирж өгнө.

БУСАД ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРҮҮД

Японы Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт дөрвөн үндсэн чиглэлээс гадна 3 төрлийн хөтөлбөр байдаг. Уг хөтөлбөр нь Төрийн албан хаагчдад илүү нээлттэй гэдгээрээ онцлогтой.

Япон хэл, Япон соёл судлаач оюутны хөтөлбөр

Зорилго: Япон хэл, Япон соёлын чиглэлээр суралцаж буй оюутнуудын япон хэл, Япон орон болон японы соёлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх
Зарлагдах хугацаа: 1 – 2 дугаар сарын үед
Шалгалт: Япон хэл
Хугацаа: 1.5 жил

Ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэргэжил дээшлүүлэх курс

Зорилго: Япон улсын их, дээд сургуульд “Сургуулийн боловсрол”-той холбоотой судалгаа хийх
Зарлагдах хугацаа: 1 – 2 дугаар сарын үед
Шалгалт: Япон хэл, Англи хэл
Хугацаа: Нэг жил

Залуу удирдагч хөтөлбөр (YLP буюу Young Leaders’ Program)

Зорилго: Төрийн албан хаагчдыг хууль, бизнесийн удирдлага, засаг захиргааны чиглэлээр магистрын курст суралцуулан төгсгөх (англи хэлээр)
Зарлагдах хугацаа: 9 – 10 дугаар сарын үед (тогтсон яам, тамгын газарт шууд хүргүүлнэ)
Шалгалт: Ярилцлагын шалгалт
Хугацаа: Нэг жил

САНАЛ АСУУЛГА

Япон улсын коллеж, их сургуульд суралцсан залуусын дунд санал асуулга явууллаа. Дараах дөрвөн асуултад нийт 150 гаруй хүн өөрсдийн сэтгэгдлээ хуваалцсан бөгөөд эрэмблэлтийн программаар хамгийн их давхардсан сэтгэгдэл, үгсийг 1-5 хүртэл байрт жагсаав. Сэтгэгдлүүдийг төлөөллөөс та бүхэнтэй хуваалцая.

Японд суралцсанаар таны амьдралд ямар өөрчлөлт гарсан вэ?

1 ЭЕРЭГ ӨӨРЧЛӨЛТ

- Мэргэжлээрээ доктор хамгаалах боломж гарснаар маш олон эерэг өөрчлөлт миний амьдралд гарсан.
- Хувь хүний хувьд бүх зүйлд ул суурьтай хандаж байх гэсэн эерэг өөрчлөлт гарсан.
- Илүү өргөн, бодит мэдээлэлд хүрэх боломж нээгдсэн. Сайн боловсрол, найз нөхөд, хань ижил, үр хүүхэд, сайхан ажил гэх мэт дандаа сайн сайхан эерэг өөрчлөлт дагуулсан.

2 ЯПОН ХЭЛ

- Япон хэл сурснаар маш том өөрчлөлт авчирсан.
- Аль ч салбарт япон хэлээрээ ажиллах өргөн боломж нээгдсэн.
- Япон хэлний болон бусад академик мэдлэг эзэмшихийн зэрэгцээ, амьдрах ухаан, бие даах, санхүүгээ зохицуулах чадвартай болсон.

3 ХАРИУЦЛАГА, ТЭВЧЭЭР

- Хариуцлага, тэвчээр хатуужилтай болж, өөрийгөө үнэлэх үнэлэмж өссөн.
- Өөртөө итгэлтэй болж, ажил, амьдралд хүлээх хариуцлага өндөр болсон.
- Аливаа зүйлд хариуцлагатай үнэнч шударга ханддаг болсон.

Японд суралцаж байх үед бэрхшээл тулгарахад та хэрхэн шийдэж байсан вэ?

1 НАЙЗ, НӨХӨД

- Хамт сурахаар очсон найз нөхөдтэйгөө ярилцах замаар бэрхшээлээ туулсан.
- Шинэ танилцсан найзуудтайгаа уулзах, алдартай газраар аялах зэргээр сэтгэл санаагаа засдаг байсан.
- Хамт сурч байсан япон найздаа хэлж тусламж хүсдэг байсан.

2 БАГШ, ЯПОН ЭЭЖ ААВ

- Сайн багш, сайхан сэтгэлтэй хүмүүсийн тусламж дэмжлэг, өөрийн чин хүсэл зоригоор даван туулсан
- Найз нөхөд, багштайгаа зөвлөдөг байсан. Амлалт, зорилгоо байнга санадаг байлаа.
- Сургуулийн багш, япон ээж аваасаа их туслалцаа авсан. Монголын ЭСЯ-тай холбогддог байсан.

3 ГЭР БҮЛ

- Гэр бүлийн гишүүд маань санхүүгийн бэрхшээлийг даван туулахад тусласан.
- Гэр бүл найз нөхөдтэйгээ зөвлөлдөж асуудлаа шийддэг байсан.
- Гэр бүлийн хүн хамт байсан болохоор харьцангуй амар байсан.

Та эх орондоо Япон улсын юуг үлгэрлэвэл хэрэгтэй гэж үзэж байна бэ?

1 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛ

- Нийтийн тээвэр, хот төлөвлөлт, үйлчилгээний соёл.
- Үйлчилгээний соёл, хүмүүсийн ажилдаа хандах хандлага, ажлын цагийг үр бүтээлтэй зөв ашиглах
- Төрийн үйлчилгээ, банкны үйлчилгээ иргэдэд харагдахаар ил явагддаг нь таалагдсан.

2 ТЕХНОЛОГИ

- Үйлчилгээний соёл, технолгийн дэвшил, хувь хүний төлөвшил ухамсар гээд их олон зүйлээр Монголоос илүү байсан.
- Үйлчилгээний соёлыг нэвтрүүлэх, япон технологийг нутагшуулах.
- Технологийн хөгжил, хувь хүний төлөвшил, бусдад төвөг удахгүй байх зэрэг олон зүйлсийг олж харсан.

3 ХОГНЫ СОЁЛ

- Хог хаягдлыг дахин боловсруулах, цэвэрхэн ариун цэврийн өрөө тухайн газрын нүүр царай мэт чухалчилж авч үздэг байдал.
- Хог ангилах, ялгах зэрэг хогтой харьцах соёл, хог боловсруулах үйлдвэр, үйлчилгээний байгууллага болон засаг захиргааны хүнээ дээдэлсэн сэтгэл.

Японы юу таны гайхшралыг хамгийн ихээр төрүүлдэг байсан бэ?

1 СОЁЛ, ЗАН ЧАНАР

- Япон соёл, хөгжил нь үнэхээр сайхан сэтгэгдэл төрүүлсэн.
- Бүх зүйл иргэнд ээлтэй ая тухтай байх боломж, хэнийг ч орхидуулахгүй байх зарчим.
- Хотын төвийн газар болон хөдөөний орон нутгийн соёл их ялгаатай байсан. Хөдөө орон нутаг нь найрсаг, хүлээж авахад гоё илүү монгол маягийн амьдрал ахуй байсан.

2 ҮЙЛЧИЛГЭЭ

- Ажилсаг, үйлчилгээний хүмүүсийн хүндэтгэлтэй харилцаа.
- Үйлчлүүлэгчээ хүндэлж харьцах үйлчилгээний ажилтан, нийтийн тээврийн зохицуулалт маш их таалагдсан .
- Байгалийн гамшгийн үед үргэлж тайван ёс зүйтэй хүлээцтэй тэвчээртэй хандаж байгаа байдал. Үйлчилгээ бол ярих юм биш.

3 ЦЭВЭР ЦЭМЦГЭР

- Газар доогуур байдаг усан суваг, өвөл замын цасаа газар доорх усан сангийн сувгаар цэвэрлэдэг, бүх хүмүүс нь цагийг яг баримталдаг.
- Япон улсын цэвэр цэмцгэр байдал, Япон хүн-үйлчилгээний соёл, дотуур байрны цэвэр тохилог байдал.

Цахим хуудсаар зочлоорой

ЯПОН ХЭЛНИЙ ТҮВШИН ТОГТООХ ШАЛГАЛТ (JLPT)

1 Та уг вэб сайтаас Япон хэлний түвшин тогтоох шалгалтын тухай мэдээлэл, япон хэлний N1 – N5 түвшинг тодорхойлох арга, шалгалтын үе шат, шалгалтын бүртгэлийн заавар зэрэг төрөл бүрийн мэдээллийг авах боломжтой.

ЯПОНД ХУВИЙН ЗАРДЛААР СУРАЛЦАХ ОЮУТНЫ ШАЛГАЛТ (EJU)

2 Та уг вэб сайтаас Япон хэлний түвшин тогтоох шалгалтын тухай мэдээлэл, япон хэлний N1 – N5 түвшинг тодорхойлох арга, шалгалтын үе шат, шалгалтын бүртгэлийн заавар зэрэг төрөл бүрийн мэдээллийг авах боломжтой.

МОНГОЛ – ЯПОНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

3 Англи болон япон хэлээр мэдээлэл авах боломжтой. Япон улсад хувийн зардлаар хэрхэн суралцах, элсэлт авах хугацаа, боломжийн талаар мэдээллүүд уг сайтад бий.

ЯПОНД СУРАЛЦАХ МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ ЯАРМАГ

4 Япон улсын их сургуулийн мэдээ, мэдээлэл, хэрхэн суралцах, сургуулийн танилцуулга зэрэг олон талын мэдээллийг нэг дор авах боломжтой.

ЯПОН ЭСЯ – НЫ ЦАХИМ ХУУДАС

5 Энэхүү хуудаснаа Япон улсын албан ёсны мэдээ, мэдээллийг авах бөгөөд Япон улсад суралцах тэтгэлэгт хөтөлбөр болон хоёр орны хамтын ажиллагааны олон талын мэдээллийг албан ёсоор авах боломжтой.

ЯПОНЫ ЭСЯ – НЫ FACEBOOK ХУУДАС


6 Сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг цаг алдалгүй авах боломжтой. Та тус хуудсанд нэгдсэнээр япон дахь боловсрол, соёл, шинжлэх ухаан, Япон улсын Засгийн газрын мэдээ, мэдээллийг авна.

ЯПОН ЭСЯ – НЫ YOUTUBE ХУУДАС

7 Subscribe дагаснаар видео хэлбэрээр олон талын мэдээ, мэдээлэл авах боломжтой. Илүү дэлгэрэнгүй, сонирхолтой хэлбэрээр Япон улсын боловсрол, соёл, шинжлэх ухаан зэрэг төрөл бүрийн мэдээлэл аваарай.

Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрүүд болон их, дээд сургуулиудын дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудсуудаас авах бүрэн боломжтой


SCAN ME




SCAN ME



SCAN ME



SCAN ME




SCAN ME




SCAN ME



SCAN ME





Ж.Болдмаа



Д.Мөнхбат



С.Энхбаяр

ЯПОНД ТӨГСӨГЧИД ЯРЬЖ БАЙНА:

Ж.Болдмаа
Д.Амаржаргал
Н.Бямбадорж
Д.Мөнхбат
З.Сугар
Д.Тэгшжаргал
С. Энхбаяр
Л.Анхбаяр
Б.Билэгсайхан

Залуусын үр чадвар, мэдлэг боловсролд тулгуурласан олон төрлийн боловсролын тэтгэлэгт хөтөлбөр бий. Хэрэв та өөрийн хичээл зүтгэл, тэмүүлэлдээ хөтлөгдвөл 100 хувийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжтой. Япон улс нь 1954 оноос Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрөө зарласан. 1974 онд хоёр орны соёлын хэлэлцээрийн дагуу манай улсын анхны оюутан Япон улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрөөр (Монбүшё) суралцсан байдаг. Тэр цаг үеэс хойш олон мянган залуус Япон улсад суралцаж, дэлхийд үнэлэгдэх боловсролыг эзэмшээд байна. Монбүшё хэмээн нэрийдэх болсон тус хөтөлбөрт амжилттай хамрагдсан залуусын төлөөлөлтэй ярилцлаа.

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Япон хэлний талаар яриагаа эхлэе гэж бодлоо. Тус хэлтэй нөхөрлөж эхлэсэн дурсамжаасаа хуваалцвал?

Б Миний ээж япон хэлний багш. Багаасаа япон хэлний ном зохиол уншиж, япон дуу дуулж өссөн. Нийгата мужид найман настайдаа очиж япон хэлийг сурч эхэлсэн.

А Япон драм үзээд л сонирхож эхэлсэн. Ахлах сургуулийн үед Кимүра Такуяа гэдэг жүжигчин байсныг тод санаж байна.

Б 2002 онд Япон улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт тэнцээд тус улсыг зорисон. Япон хэлтэй нөхөрлөж эхэлсэн нь нэлээд хожуу байсан. Бараг чих онгойгоод эхлэх үед. Улмаар япон ханз бичигт илүү татагдаж, муж газруудынх нь аялага сонирхолтой санагдаж эхэлсэн.

М Миний хувьд Япон улсын Засгийн газрын шалгалтад тэнцчихээд япон хэлтэй анх танилцсан. Хөтөлбөрт хамрагдсан оюутнууд Японд очоод эхний нэг жил япон хэлний бэлтгэл сургуульд суралцдаг болохоор тэндээ илүү сайн сурсан.

С "Шинэ Монгол" ахлах сургуульд суралцах үед япон хэлийг анх сурч эхэлсэн.

Т Япон хэлтэй учирсан үе гэвэл 1990–ээд он. Тэр үед "Сакура" сэтгүүл гэж байсан. Япон хэлний хичээлтэй болохоор ээж минь байнга авчирна. Би бол нэг л япон үг мэддэг байсан. Яг япон хэлийг суралцаж эхэлсэн үе гэвэл, Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт тэнцээд Японд очсон хойноо А–гаасаа эхлэн суралцаж, дараагаар нь Бизнес, үйлчилгээний япон хэлийг түлхүү шимтэн сурч эхэлсэн.


Э Японд очоод л сурч эхэлсэн.

А 18 настайгаасаа япон хэл сурч эхэлсэн. Анхандаа ханз цээжлэх, ханзаар бичиж сурах гэж бас л хөөрхөн будилж билээ. Тэгээд яваандаа гайгүй болсон.

Б Намайг сурагч байхад Асашёорюү Дагвадорж од байлаа. Сүмо үздэгүй монгол хүн гэж байгаагүй. Япон улс, соёлын тухай хүн бүр л сонирхсон үед аавминь "Шинэ Монгол" япон стандартын ахлах сургууль нээгдэж байгааг надад дуулгасан. Би ч тус сургуульд орсон, япон хэлээ ч үзэж эхэлсэн.


Нэгэнт дурсамж сэдэрсэн болохоор (инээв) Япон улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөртэй танилцсан түүхээсээ сонирхуулбал?

Б Тус улсад хагас жил амьдраад Японд буцах хүсэл тэмүүлэлтэй болсон. Залуу хүний хувьд суралцах нь хамгийн оновчтой шийдвэр болохоор өөрт тохирох боломжуудыг хайсан. Нэлээд хугацааны дараа (ЕБС–ийн VIII анги) Япон улсын Элчин



Д.Амаржаргал

Н.Бямбадорж



З.Сугар

Д.Тэгшжаргал

сайдын яамны мэдээллийн сайтаас Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн тухай уншаад зорилгоо тодорхойлсон.

А Тухайн үед бүх оюутнууд л тэтгэлэгт хамрагдах сонирхолтой байлаа. Анагаахын оюутны хувьд тэтгэлэгт тэнцэнэ гэдэг маш хэцүү. Вьетнам, Орос, Хятадын тэтгэлэг байсан л даа. Гэхдээ Японы тэтгэлэг илүү боломж өгөх юм шиг санагдаж байсан. Их сургуулиа төгсөөд "Судлаач оюутан" тэтгэлэгт хамрагдаж, магистр хамгаалах боломжтойг сонин дээрээс уншсан. Тэгээд л бэлтгэж эхэлсэн.

Б Их сургуулийн I курст гадаад руу тэтгэлгээр явах боломжтойг мэдсэн. Сургуулийн зарлалын самбараас тэтгэлэгт хөтөлбөрийн мэдээллийг уншаад эхний жил өгсөн боловч тэнцээгүй. Дараа жил нь шалгалтад илүү сайн бэлдэх ёстойг ойлгосон. Сайн ч бэлтгэж эхэлсэн.

М Их сургуулийн II курст байхад (2000 он) өнөөгийн түвшинтэй харьцуулахад интернет өргөн тархаагүй, мэдээллийн суваг ч хомс. Өөрийн эргэн тойрон, танилын хүрээ, хичээл зүтгэлээр мэдээлэл авдаг байлаа. Хамгийн чухал мэдээллээ (Тэтгэлэг хөтөлбөрийн талаар) ч эрэл сурал дундаас олж чадсан. Тэгээд л яаран сандран шалгалтаа өгч байлаа.

С Манай авга эгч Япон улсын Засгийн газрын тэтгэлэгт 1998 онд хамрагдсан болохоор сайн мэддэг байлаа. Тэтгэлэгт хамрагдахын тулд шалгалтад тэнцэх, мэдээлэл сайтай байх хэрэгтэй гэж бодож байсан. Энэ талаар "Шинэ Монгол" ахлах сургууль туршлагатай байсан учраас тус сургуульд суралцсан. Дараа нь тэтгэлэгээ ч авч чадсан.

Т Сурагч байхад зурагтаар "Япон улсад сургуульд явуулна" гэх зар байнга гардаг байлаа. Аав түүнийг үзээд "Охиныгоо л Японд явуулахсан" гэж ярьдаг байлаа. Гэтэл, оюутан болсон хойно манай ангийн найз охин Япон улсын тэтгэлэгт хөтөлбөрийн талаар сонин дээр бичсэн тухай хэлсэн. Тэр найзтайгаа хамт явж бүртгүүлээд, бэлдэж, шалгалтаа өгч байсан.

Э Миний үед дээд ангийн ах нар тооны олимпиадад оролцоод л Япон явчихдаг байлаа. КТМС—ийн II курст байхад хөтөлбөрийн тест явж байна оролцох уу гэхээр нь тэгье гээд бүртгүүлж байв. Тэтгэлгийн шалгалт байдгийг мэддэг байсан ч ямархуу маягаар яаж явдгийг тэр үед л анх мэдэж билээ. Шалгалтад бэлдье гэсэн ч мэдээлэлгүй ч шууд орж байлаа.

А Монбүшёо буюу Засгийн газрын тэтгэлгийг хоёр төрлөөр авах боломжтой. Нэг нь Монгол дахь Япон Улсын Элчин сайдын яам, хоёр дахь нь Японы их сургуулиар дамжаад Япон Улсын Боловсролын яам. Миний хувьд хоёр дахь боломжийг ашигласан. Нагоя их сургуульд тэнцээд тэндээсээ Япон улсын Боловсролын яамнаас Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан.

Б Миний зорилго Япон улсад тэтгэлгээр суралцах байсан. Засгийн газрын тэтгэлэгт тэнцэхийн тулд "Шинэ Монгол" ахлах сургууль суралцаж эхэлсэн.

Олон залуус шалгалт өгөхөөр, мэдээлэлтэй танилцаж байгаа байх. Тус тэтгэлэгт тэнцэхийн тулд хэлний болон суурь мэдлэг хоёрын аль нь илүү чухал вэ?

Б Шалгалтын материалаа ойлгох чадвартай бол (англи, япон хэл) математик, дэлхийн түүхийн хичээлийг сайн бэлдэх хэрэгтэй.

А Намайг шалгалт өгч байхад нэг эгч өөрийнхөө эссэг монгол хэлээр бичээд тэнцэж байсан. Тэгэхээр хэлний мэдлэг гэхээсээ илүү суурь мэдлэг чухал байх. Японд очоод хэлийг бол эхнээс нь сурах боломжтой.

Б Миний хувьд англи хэлдээ тийм ч сайн байгаагүй. Харин математиктаа илүү сайн байсан.

М Би хоёр удаа Япон улсын Засгийн газрын тэтгэлэгт хамрагдсан. 2004 оны анхны шалгалт англи, монгол хэл дээр, хоёр дахь нь англи, япон хэлээр байсан.

С Шалгалтын материал англи хэлээр байсан. Байгалийн ухааны их сургууль учраас математик, хими, физик, англи хэл заавал өгөх, япон хэлийг заавал өгөх шаардлагагүй гэж байсан. Гэхдээ энэ таван хичээлээ шалгалтаа өгсөн.

Т Мэргэжлийн сургуульд өрсөлдсөн болохоор математикийн шалгалт чухал байсан. Математиктаа тэнцээд англи хэлний шалгалтаа өгч байсан.

Тэтгэлэгтээ тэнцээд Японд хөл тавихад тохиолдсон хөгжилтэй дурсамжаас хуваалцана уу?

Б Том хотод ирсэн юм шиг санагдаж байсан. Өмнө нь очсон Нийгата мужаас (хөдөө) тэс өөр мэдрэмж төрсөн.

А Монгол хүн гадаадад очихоор "хонь" үнэртээд байдаг тухай явган яриа сонссон. Онгоцноос буугаад л угтаж буй Японд хүнээс "надаас ямар нэг эвгүй үнэр үнэртэж байна уу" гэж асуусан. Тэгсэн нөгөө хүн чинь аймар гайхаад л бага зэрэг үнэрлэж үзээд "үгүй" байна гэж хэлэхэд сэтгэл амарч билээ. (инээв)

Б 20 насныхаа төрсөн өдрөөр анх удаа онгоцонд сууж, анхны гадаад орон Японд зорчиж байлаа. Анхны сэтгэгдэл гэвэл бүх зүйл маш цэвэрхэн байсан. Биднийг сургууль руу явахад таксины арын суудалд хоёр л хүн суулгасан. Маш их гайхаж билээ. Ягаад гурав эсвэл дөрвөөр нь суулгахгүй байгаа юм бол оо гэж. (инээв)

М Японы гаалийн шалган нэвтрүүлэх зааланд ирэхэд шууд л намайг шалгаад эхэлсэн. Анх удаа ирсэн хүмүүсийг анддаггүй юм билээ. Тэгээд хоёр жил Японд сурсны дараа хоёр дахь удаа нэвтрэхдээ "Бүх бичиг баримтаа бэлдээд л шалгуулах бэлтгэлээ базаагаад очсон чинь" , "Тавтай морил" гээд л оруулчихсан. Тэр ер санаанаас гардаггүй юм.

С Тэтгэлгийн шалгалтаа өгснөөс хойш Япон явах хүртэл нэг жил орчим хугацаа өнгөрсөн. Их удаан хүлээсэн болохоор маш их баяртай байсан. Хэлний сургуульд, хичээл эхлэхээс долоо хоногийн өмнө очсон болохоор их сонин, зуслан шиг л санагдаж байсан.

Т Монголд дөрөвдүгээр сард хүйтэн болохоор ноосон өмдтэй очсон. Тэгсэн маш их чийгтэй уур амьсгал угтаж авсан. Онгоцны буудлаас тоссон машинд суугаад амьдрах дотуур байр руу явж байх үед анх удаа харж байсан Япон маань гудамж талбай, машин зам нь саяхан угаачихсан юм шиг л харагдсан. Машинд явахдаа хоёр тийшээ ээлжлээд хараад явсан, яг л адилхан, хүмүүсийг нь ажиглахаар гутал нь хүртэл цоо шинэ юм шиг л тийм цэвэр орчин угтсан. Миний хамгийн анхны Японд идсэн хоол Якисоба байсан. Биднийг тосч авсан Монгол эгч, "Монгол цуйван шиг хоол" гэж зөвлөөд авч идэж байсан дурсамжаа мартдаггүй.

Э Японы онгоцны үйлчлэгчийн харилцаа их сайхан санагдсан. Чийглэг, гэрэл гэгээ болсон хотод шөнө бууж байлаа. Өмнө нь Хонгконг явж байсан болохоор тодорхой хэмжээний төсөөлөлтэй байсан. Яг л тэр төсөөллийн дагуу гоё цэвэрхэн орчинд очиж байлаа.

А Өөрийн хүссэн сургууль явсан болохоор тухайн үед маш их догдолж байсан л санагдаж байна.

Б Тэтгэлгийн өмнө Токио хотод нэг жил орчим амьдарсан. Токио бол маш их хүн, хөл хөдөлгөөн ихтэй Японы хамгийн том хот. Япон улсыг Токиогоор л төсөөлдөг байлаа. Тэтгэлэгт тэнцээд Окинава руу (японы арал) сурахаар явсан. Хот суурин, өндөр барилга хайгаад л байсан, тэгсэн далайн эргийн дэргэдэх уулын орой дээр манай сургууль байсан. Маш гайхалтай тэс өөр мэдрэмж төрсөн.

Одоо бүгдээрээ сэдвээ өөрчилж, гүнзгийрүүлэе. Японы боловсрол дэлхийн боловсрол мөн үү?

Б Мэргэжил салбараас их шалтгаална. Эрүүл мэнд, эдийн засаг, технологийн салбар хамгийн хүчирхэг байдаг.

А Анагаахын салбарын хүн. Тус салбарын суурь болон клиникийн судалгаа Японд маш сайн хөгжсөн. Японы топ сургууль орох тусам дэлхийн боловсролыг олно.

Б Хүнээсээ л шалтгаална. Дэлхийн хэмжээний үндэстэн дамнасан компаниудад ажиллахад миний эзэмшсэн боловсрол гологдохгүй гэж боддог.

М Дэлхийн топ 100 сургууль багтдаг Японы сургууль олон бий. Эдгээр сургуулийн боловсрол дэлхийн боловсрол мөн үү гэвэл мэдээж тийм. Миний хувьд Англи, Америкт тодорхой хэмжээнд суралцаж байсан. Гэхдээ их сургуулийн суурь боловсролыг Японд эзэмшсэн нь надад маш их давуу тал болдог. Цааш хөгжих, өрсөлдөх чадварыг бүрэн эзэмшсэн гэж боддог.


С Сургуулиас их шалтгаална. Жишээ нь би Осака, Сайтама их сургууль хоёрт сурсан. Осака их сургууль улсдаа эхний III жагсдаг. Багш нарынх нь өгөх даалгавар, харах өнцөг, амбиц нь маш өндөр.

Т Миний хувьд Японд Зочид буудал, үйлчилгээний чиглэлээр мэргэжил эзэмшсэн. Уг салбар Японд чансаа өндөрт ордог. Удирдлага гэхээсээ илүү халуун цэгт ажиллах, үйл ажиллагааны удирдлага чиглэлээрээ илүү мэргэшүүлдэг давуу талтай.

Э Би Кёотогийн их сургуульд мастер хамгаалсан. Манай сургуулиас жил бүр л бараг Нобелийн шагналтан төрж байсан. Тэгэхээр дэлхийн хэмжээний боловсрол мөн гэж бодож байна. Гол нь хүн өөрөө юу сурч авч үлдэх вэ гэдэг их чухал.

А Би өөрөө хуулийн салбарын хүн. Тэгэхээр тэр салбарын өнцөгөөс нь авч үзье гэж бодож байна. Дэлхийд эрх зүйн тогтолцоо үндсэндээ дөрвөн том бүлд хуваагддаг. Социалист, Шашны, Англи—Саксон, Ром—Германы бүл. Монгол Улс 1992 онд Үндсэн хуулиа батлахдаа Ром, Германы эрх зүйн бүл дээр үндэслэсэн. Япон улсын хувьд мөн адил. Тиймээс Монголын хууль тогтоомжтой харьцуулсан судалгаа хийхэд дөхөм. Түүнчлэн Японы хууль эрх зүйн салбарын судалгаа, шинжилгээ өндөр түвшинд хөгжсөн байдаг учраас Японд хуулийн мэргэжил эзэмших нь давуу талтай гэж боддог. Мэдээж хуулийн яг ямар салбар, чиглэлээр суралцах гэж байгаагаасаа хамаарч аль улс оронд суралцах вэ гэдэг сонголт янз бүр байх. Жишээ нь, компанийн эрх зүйн чиглэлээр магадгүй Америк, захиргааны эрх зүйн чиглэлээр Герман ч юмуу өөр байхыг үгүйсгэхгүй. Япон улсын хувьд хими, физик, анагаах, мэдээлэл технологи, инженерийн салбартаа дэлхийн хамгийн шилдэг боловсролыг олгож байгаа.

Б Би шинжлэх ухааны салбарын хүн. Шинжлэх ухаанаараа дэлхийн ранкт жагсдаг олон сургууль Японд байдаг. Жишээ нь, манай сургууль дэлхийд ашиглагдаж байгаа хамгийн сүүлийн үеийн технологиудыг лабораторитоо ашигладаг.



Л.Анхбаяр

Б.Билэгсайхан

Японд суралцсанаар таны амьдралд ямар өөрчлөлт гарсан бэ?

Б Гоё асуулт байна. Нэгдүгээрт, өөрийн гаргах шийдвэр, санхүү дээр бие дааж сурсан. Хоёрт, Япон улсад сурахаар ажлын байр их өөр болдог. Японд их сургуулиа төгсөөд танд чадвар байгаа л бол япон дахь аль ч компанид ажиллах боломжтой. Гуравт, зөв хүн болж төлөвшсөн.

А Японы "Хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн төв" буюу хүүхдийн гуравдугаар шатлалын эмнэлэгт судлаачаар (research fellow) таван жил ажилласан. Энэ хугацаанд Японы боловсролын яамнаас судалгааны ажилдаа санхүүжилт авч чадсан. Энэ бол маш том итгэл, бас хариуцлага. Япон бол гадаад дотоод гэлтгүй бүх судлаачдад тэгш боломж олгодог. Тэр санхүүжилтээрээ Монголын эх хүүхдийн эрүүл мэндийн талаар эх орондоо судалгаа хийж олон өгүүлэл хэвлүүлж чадсан. Ингэж монголчуудынхаа төлөө бага ч болов хэрэгтэй зүйл хийх завшаан тохиолдсонд баярладаг. Японд сурсан хамгийн чухал нь бүтээлч байдал. Нэг зүйлийг хийхдээ заавал ард нь гарч чаддаг болсон гэж боддог.

Б Японы их сургуульд орсон хойно Жүдогийн дугуйланд суралцсан. Гол зорилго нь япон хүмүүстэй харилцаж, япон хэлээ улам сайжруулах. Мэдээж хэл сайжирч эхэлсэн. Гэхдээ хэлнээс илүүтэй ажлын дэс дараалал, хүнтэй харьцах харилцаа, зохион байгуулалт, япон менежментийг маш сайн сурсан. Одоо ч миний амьдралд хэрэг болдог.

М Өнөөдөр Softskill буюу ажил дээрх хандлага маш чухал болсон. Найрсаг, соёлтой хандлага, зөв харилцаа нь ажлын карьерт ч ихээр нөлөөлдөг. Нэгт, энэ чадварыг би Японд эзэмшсэн. Хоёрт, япончуудын хөгжлийн нууц нь багийн ажиллагаа юм. Энэ чадварыг эзэмшсэн нь миний амьдралд нөлөөлсөн. Гуравт, төлөвлөх гэдэг зүйлийг сурсан. Энэ нь цаг хугацааг маш их хэмнэдэг.

С Японд сурснаар ажилд орох, АНУ, Европын орнуудад аялах, олон оронд визний босго зөөлрөх гэх мэт материаллаг давуу тал их байдаг. Гэхдээ үүнээс илүү миний хувьд ертөнцийг үзэх үзэл их өөрчлөгдсөн гэж боддог. Ажил хийхдээ сэтгэл хөдлөл, амбицаа заагла. Зөвхөн ажлын үр дүн, зорилгыг голчлохын чухлыг ойлгосон. Үүрэг хариуцлагын тухайд дааж авсанаа гүйцэтгэх, хоцрох бол заавал хэлэх гэх мэт энгийн боловч чухал соёлыг сурсан. Энэ зүйлс амьдралд маань эерэгээр нөлөөлдөг.



Т Бусдад дараа болохгүйгээр амьдрах ухааныг сурсан. Мөн эерэг дадлуудыг сурсан болов уу. Эрүүл, хөдөлгөөнтэй байх, эрүүл хооллох гэх мэт. Идэх зүйлд маш их ач холбогдол өгнө. Ажлын чиглэлээр бол японы үйлчилгээ, харилцааны соёлыг сурч, ажилласан туршлага минь АНУ-д ажиллах гарц болсон.

Э Монголоос өөр соёлыг сурлаа. Түүнийг дагаад харах өнцөг өөрчлөгдсөн гэж боддог. Мөн сайн компанид ажиллаж байсан болохоор ажлын шугамаар дэлхийн 10 гаруй оронд томилолтоор явж олон орны хүмүүстэй танилцсан хамтарч ажиллаж үзлээ. Энэ нь эргээд амьдралд том боломжуудыг нээж өгдөг.

А Багаар ажиллах, ажлыг чанартай гүйцэтгэх арга барил болон хувь хүний хөгжилд талд нэлээдгүй дэвшил гарсан.

Б Хувь хүний төлөвшил минь Японд бий болсон. Мөн Япон хэл, англи хэлийг сурснаар мэдээлэл авах суваг маш олон болдог. Олон өнцгөөр мэдээлэл авах нь дараагийн алхам хийх, шийдвэр гаргахад том түлхэц болдог. Үүнийг дагаад амьдралд ч өөрчлөлт гардаг.

Японд суралцаж байх үед бэрхшээл тулгарахад хэрхэн шийдэж байв?

Б III курст байхад Хаврын баяр зохион байгуулах даргаар ажиллаж байлаа. Гэтэл манай аавөвдөөд Монгол явах шаардлага гарсан. Тэр үе их хэцүү байсан. Гэхдээ гэр бүлийнхээ энэ шалтгааныг хэлэлгүй, ажлаа орхиод Монгол явсан. Одоо бодохоор тухай үед хамт олондоо хэлээд ажлын зохион байгуулалтаа хүмүүстээ даатгачихаад явах хэрэгтэй байсан юм гэж боддог.

А Эхний семестр дуусаад их удаан амардаг болохоор (хоёр сар гаруй) бүх оюутнууд гэртээ харьдаг. Миний хувьд мөнгөө хэмнэж, компьютер авах гээд хариагүй. Нэг мэдсэн хэнтэй ч юу ч ярихгүй нэг сар орчим амьдарсан байсан. Энэ нь сэтгэл гутралын эхний шинж тэмдгийн илрэх шалтгаан болдог юм билээ. Тэр үед "Өдөр бүр хүнтэй юм ярьж байхгүй бол болохгүй шүү" гэж анх Японд тосч авсан хүн захиж байсныг санасан. Хүчээр ч хамаагүй хэн нэгэнтэй ярилцах хэрэгтэй. Мөн сэтгэл санаагаа сайжруулахын тулд дасгал хөдөлгөөн хийх хэрэгтэй. Зөвхөн номын санд суугаад байж болохгүй.

Б Их сургуулийн лекц анх сонсоод юу ч ойлгоогүй. Хэрхэн япон хэлээ сайжруулах, яаж хичээлээ хийх тухай бодоход л маш хэцүү санагдсан. Энэ бэрхшээлийг туулах миний гаргалгаа бол япон хүмүүстэй байнгын харилцаатай байх. Тиймээс дугуйланд орсон. Япон суралцах үед бэрхшээл тулгарвал туслах байгууллага, систем их бий. Гадаад оюутан хариуцсан хэлтэс хүртэл байдаг. Хоумстей, Хостфамили зэрэг төсөл хөтөлбөр ч бий. Үүнийг ч ашиглаад бэрхшээлийг туулах боломжтой.

М Таван жил Засгийн газрын тэтгэлгээр суралцаад, дараа нь гурван жил хувиараа суралцсан. Тэтгэлэгээр суралцахад их амар, олон зүйлс цаанаасаа шийдэгдээд явчина. Хувиараа сурахад бэрхшээл тулгарна. Хамгийн эхнийх нь санхүү. Үүнийг шийдэхийн тулд арабайт буюу цагийн ажил хийнэ. Ажиллаад ирэхээр хичээлийн тэнцвэр алдагддаг. Мөн ганцаараа байх, ганцаардалд орох зэрэг бэрхшээл ч тулгарна. Үүнийг даван туулахын тулд бассейнд явж эхэлсэн. Тэр үед 30 кг жин хасч, бэрхшээлээ давж байлаа.

С Японд их сургуулиа солих үеийн шийдвэр маш хэцүү байсан. Учир нь дараагийн туулах зам, үр дагавар нь хүнд санагдсан. Гэр бүлийн хүн, найз нөхдийнхөө зөвлөгөө, дэмжлэгээр давж чадсан.

Т Эхний жил учраа сайн олохгүй мунгинаж явахад Хостфамили хөтөлбөрт хамрагдсан. Энэ хөтөлбөр нь Япон айлд амралтын өдрөөр очиж, япон соёл, амьдралтай танилцдаг. Хөтөлбөрт оролцож буй Японы айлын хүмүүс ч маш их тусладаг. Бас Японы дахь Монгол оюутнуудын холбоонд (ЯМОХ) элссэнээр олон найзуудтай болсон. Хол газар дэргэд минь байгаа найз нөхөд бэрхшээлийг даван гарахад маш их дэм болдог.

Э "Хаана ч явахад туслах хүн бий" гэх япон үг бий. Японд төөрөөд явахад танихгүй хүн тусалж байсан удаа бий. Сайн хүн заавал таарна. Ганц Япон гэлтгүй дэлхийн бүх л улсад байгаа. Өвдөх үед, мэдэхгүй чадахгүй юм гарахад хажууд байгаа найз нараасаа туслалцаа авч олон хүнд үеийг давж гарч байлаа.

А Сурахын зэрэгцээ Нагояагийн Их Сургуулийн харьяа CALE (Center for Asian Legal Exchange) гэж төвд туслахаар, мөн их сургуулийнхаа профессорын туслахаар (teaching assistant) хэсэг хугацаанд ажиллаж үзсэн. Тухайн үед Япончуудын ажилдах арга барилд хэсэгтээ дасаж өгөхгүй хэцүү үе байсан ч Япон хүмүүсийн заавар зөвлөгөө тусламжтайгаар асуудлаа аятайхан шийдэж байсан. Үүнээс бусдаар гэвэл суралцах үед ямар нэгэн асуудал тулгарч байгаагүй санагдаж байна.

Б 10 жилээ төгсөөд шууд Япон явсан болохоор хол газарт хэцүү санагдаж байсан. Гэхдээ Засгийн газрын тэтгэлгээр очвол туслах, харгалзах хүн заавал бий. Надад бол хоёр тютер буюу туслах оюутан өгсөн. Шинэ орчинд дасан зохицоход эдгээр оюутнууд маш их тусладаг. Мөн багш нар тусалдаг. Энэ нь их амар байсан. Ер нь тэтгэлгийн систем нь маш сайн болохоор очсон оюутнуудад их хэрэг болдог.

Монголд юуг нэвтрүүлэе гэж бодож байсан бэ?

Б Их л олон зүйл байгаа. Гэхдээ төрийн үйлчилгээг нэвтрүүлэх хэрэгтэй.

А Япон нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй улс. Тэд хаана ч бие даагаад зорчих боломжтой. Бүх зүйлс нь маш хялбар байхаар зохион байгуулсан байдаг. Үүнийг эх орондоо нэвтрүүлэхийг хүсдэг. 2011 оны цунамигийн хүнд үед Япон хүний ёс зүйг үнэхээр биширсэн. Бие биенээ маш их боддог. Гэрлэн дохио эвдэрсэн байхад ч машины зорчих хөдөлгөөн нэгэн жигд үргэлжилж байсан нь гайхалтай. Ийм ёс зүй Монгол хүнд урьд нь байсан байх. Харин одоо сэргээх хэрэгтэй гэж боддог. Японд нэвтрүүлмээр зүйл гэвэл монголчууд хүүхдээ хангалттай удаан буюу дунджаар хоёр жил эхийн сүүгээр хооллодог. Миний хийсэн судалгаагаар дан эхийн сүүгээр бараг бүх Монгол ээж буюу 94 хувь нь эхний 4 сар хөхүүлдэг нь тодорхой болсон. Эрүүл нийгмийг дэлхийн бусад орон ч хэрэгжүүлээсэй гэж хүсдэг.

Б Японд шинэ ажилтанд зориулсан сургалт гэж бий. Ажлыг хэрхэн хийх, юун дээр анхаарах, дэс дараалал гэх мэт олон анхан шатны зүйлсийг заадаг. Би ч энэ зарчмаар ажлын гараагаа эхэлсэн. Монголд ажиллахад энэ сургалт хэрэгтэйг анзаарсан. Ажлын систем, харилцаа, хандлага гэдэг зүйлийг заавал эхэнд нь суурьтай заах хэрэгтэй. Японд бол түрүүн хэлсэнчлэн сургалтаар заадаг. Энэ сургалтыг Монголдоо нэвтрүүлвэл ажлын үр бүтээл, ёс зүй сайжирна гэж боддог.

М Бямбагийн яриаг үргэлжлүүлэхэд Японд Ментор гэж байдаг. Ямарваа зүйлийг заавал зааж өгдөг хүн гэсэн үг. Уламжлан мэргэшүүлэх систем ч гэсэн болно. Энэ бол заавал байх ёстой. Шинэ ажилтан юу хийхээ мэдэхгүй, компьютерын ард сууж болохгүй. Ажлыг нь хөтлөөд уламжлаад, сургаад явах хэрэгтэй.

С Хүн хүнээ гэсэн ёс зүйг сайн суулгах хэрэгтэй. Өөрөөсөө гадна хамт нэг баг болж байгаа хүмүүс, найзууд, нийгэм маань юу хүсч байгааг ойлгох, яавал хамтын тусын тулд юм хийж болох вэ гэдгийг байнга боддог, анзаардаг байх хэрэгтэй гэж бодогддог.

Т Нэгж хорооны үйлчилгээ сайн байвал төрийн үйлчилгээ сайжирна. Үүнд хөршийн холбоо тун чухал. Япон улсад иргэн бүр хороо, өрхийн ажилд маш сайн хамтарч оролцдог. Энэ уялдаар Монголд нэвтрүүлэх хэрэгтэй.

Э Хэн нэгэн өөрт нь жаахан ч гэсэн тус болоход маш гоёор талархаж чаддаг. Энэ их зөв санагддаг. Монголд бол эсрэгээрээ байдаг.

А Монгол Улсад төрийн үйлчилгээг хүртээмжтэй, ил тод, үр ашигтай хүргэх механизмыг илүү сайжруулах шаардлагатай байгаа. Энэ үүднээс Япон Улсын төрийн үйлчилгээний сайн туршлагыг судлах нь үр дүнтэй байх боловуу гэж хувь хүнийхээ хувьд бодож явдаг. Төрийн үйлчилгээ нь иргэдэд ойлгомжтой, хүнд сурталгүй, ил тод, хүртээмжтэй байх нь хамгийн чухал. Японд төрийн үйлчилгээг иргэдэд хэрхэн хүртээмжтэй, оновчтой, шуурхай хүргэх тал дээр маш ойлгомжтой системчилсэн арга барилтай. Энэ бол япон хүмүүс ёс зүйтэй мундаг болохоороо хийж чадаад, монголчууд хийж чадахгүй байгаа юм бол биш ээ. Япончууд зүгээр л оновчтой систем бүхий арга барилд л дадсан, түүнийгээ залгамж халаатай сайн хэрэгжүүлж байгаад л учир бий.

Б Мэдээж төрийн үйлчилгээ. Тэр дундаа шуудангийн үйлчилгээг ашиглах хэрэгтэй. Жишээ нь, 20 нас хүрэхэд төрийн байгууллагаас ямар төрлийн хариуцлага үүрэх, хаана очиж юу лавлах, бүртгүүлэх, хэрэгжүүлэх, хийх тухайг маш ойлгомжтойгоор тайлбарлаад зөвлөмжийн хамт шуудангаар илгээдэг. Маш энгийн хэн бүхний мэддэг зүйл мэт боловч заавар зөвлөгөөг өгөх нь хамгийн чухал. Иргэдэд мэдээлэл хүргэх уг аргачлалыг нэвтрүүлэх нь чухал.

Японы Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрөөс гадна Японд суралцах тэтгэлэгт хөтөлбөрийн сонголт, боломжууд хэр байдаг вэ?

А Анагаахын салбарт бол ЭЙ ДИ БИ (Азийн хөгжлийн банк) тэтгэлгээр хүмүүс их суралцдаг.

Б Хамгийн сүүлийн үед сонсогдож байгаа нь Жи Ти Эс Japanese Development Төрийн албан хаагчийн тэтгэлэг. Мөн дэлхийн банкны хөтөлбөр, Монбучи, Нихон Рюгакү Шикин (Төвшин тогтоох шалгалт) шалгалтаар өндөр оноо авбал Япон улсад "Тэтгэлэгт" хамрагдах боломж бүрддэг. Түүнчлэн эхний нэг жилдээ Японд сайн сурвал хоёр дахь жилээс олон төрлийн тэтгэлэг нээлттэй. Ротаригийн тэтгэлэг монголчуудад их нээлттэй байдаг. Бакалавраас гадна мастерын тэтгэлэг ч сайн өгдөг.

М Тэтгэлгийг Монголд зарлагдаж буй тэтгэлэг, Японд сургуульд суралцах үеийн тэтгэлэг гэж хоёр ангилж болно. Японы чансаа өндөр, топ сургуульд тэнцвэл маш олон тэтгэлгийн боломж байдаг. Япон улс нь дэлхийн боловсролыг Япондоо нэвтрүүлэх зорилтын хүрээнд гадаадаас олон оюутныг суралцуулах болсон. Энэ хүрээнд "ЖИ—30" хөтөлбөр явагдаж байна. Англи хэлээр шалгалт өгдөг онцлогтой. Тус хэлээр шалгалтаа өгсөн олон оюутан Японы топ сургуулиудад элссэн байдаг. Залуучуудад хэлэхэд маш сайн судалвал олон нээлттэй зам бий.

Э Хувийн тэтгэлгүүд олон төрлөөр байдаг. Жишээ нь, өндөр ач холбогдолтой судалгаа хийж буй залуусыг японы их сургуулийн тэтгэлэгт хамруулах хөтөлбөрүүд ч байдаг.

А Мэдээж олон бий. Хамгийн энгийн жишээ нь Монголын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр. Монголоос тэтгэлэг авч чадаагүй ч Японы их сургуульд тэнцвэл 50—100 хувиар сургалтын төлбөрөө хөнгөлөх, японы хуулийн этгээдүүдийн тэтгэлэгт хамрагдах зэрэг боломж өндөр. Топ сургуулиудад тэнцвэл энэ боломж улам бүр л нэмэгдэнэ. "ADB" Азийн Хөгжлийн Банк, "Ротари", "Шинэ Монгол" сургуулийн ивээн тэтгэгчдийн тэтгэлэг зэрэг мэдээллээ цуглуулж чадвал олон бий.

Б Миний ажилладаг "Жайс" (JICE) агентлаг Японы буцалтгүй тусламжийн тэтгэлэг зарладаг байгууллага. Өөрийн мэдээллээс хуваалцвал Но рёокү шикэн хэлний шалгалтад өндөр оноо авах, эсвэл Японд хэлний сургуульд нэг жил маш сайн сурвал их сургуулиуд 100 хувь хүртэл сургалтын төлбөрөөс чөлөөлдөг. Үүнд Магистрын оюутнууд ч хамрагдах боломжтой. Хувиараа суралцаж буй оюутнууд ч Японы Жассогийн (JASSO) 48.000 иэнийн тэтгэлэгт хамрагдах боломжтой. JDS гэж ажиллаж буй залуучуудад тун хэрэгтэй тэтгэлэг ч бий. Тиймээс олон талын мэдээллийг сайтар хайж, боловсруулж, судлах хэрэгтэй.

"ЖУГАМО" Японд сургууль төгсөгчдийн нийгэмлэг



"ЖУГАМО" Нийгэмлэгийн ерөнхийлөгч Батбаярын НАСАНБИЛЭГ

Хамрах хүрээ: 2000 гаран төгсөгч
Нийгэмлэгийн ерөнхийлөгч: Б.Насанбилэг
Нийгэмлэгийн гүйцэтгэх захирал: А.Амарбаяр
Удирдах зөвлөлийн гишүүний тоо: 25

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

1995 онд үүсгэн байгуулагдсанаас хойш бүх гишүүдийн харилцаа холбоог бэхжүүлэх өргөжүүлэх, Япон Монголын харилцааны хөгжилд хувь нэмэр оруулах, Эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах зорилгоор гишүүдийг хамарсан уулзалт цуглаан, сургалт, семинар, явган аялал, спортын арга хэмжээ, шинэ жил, цагаан сарын арга хэмжээнүүдийг зохион байгуулж, "Японд суралцацгаая" яармаг арга хэмжээний дэмжигч байгууллагаар ажиллахаас гадна Гадаадад Төгсөгчдийн Нэгдсэн Зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн байгууллагаар ажиллаж байгаа билээ.

ЯПОНД СУРАЛЦАХЫГ ХҮСВЭЛ

Япон бол дэлхийд эдийн засаг, технологийн хөгжлөөрөө тэргүүлж яваа орны нэг. Арлын чийглэг дулаан уур амьсгалтай, амьдрахад таатай, эрүүл, аюулгүй орон билээ. Япон хүн зочломтгой, сайхан сэтгэлтэй, харийн хүнд найрсаг байдаг. Японд дэлхийд алдартай их сургуулиудад, дэлхийд данстай багш профессор нарын удирдлага дор өндөр боловсрол эзэмшихийн сацуу, спортоор хичээллэж, ажил хийж хувь хүнийхээ хувьд бие дааж төлөвших, багаар ажиллаж суралцах боломжтой байдаг. Маш олон төрийн болон хувийн тэтгэлэгийн сан байдаг. Эзэн хичээвэл, заяа хичээнэ гэгчээр хичээллээ л сайн хийж чадвал маш олон боломжууд байдаг юм шүү. Япон хүн хөдөлмөрч, хариуцлагатай, итгэл дааж амьдрахыг ихэд эрхэмлэдэг. Энэ сайхан соёл, хувь хүний эерэг хандлагаас суралцаж дэлхийн хаана ч очсон гологдохооргүй боловсролтой, өрсөлдөх чадвартай, чадварлаг хүн болохын төлөө арлын Японд оронд суралцахыг дүү нартаа уриалж байна.

Японд боловсрол эзэмшсэн залуусын тоо 10 мянга давсан байна. Японд төгссөн Монгол оюутнуудад ажилд ороход шууд болон шууд бусаар их тусладаг. Жугамо нийгэмлэгийн хувьд жил бүр Япон улсын их дээд сургуулийн үзэсгэлэн яармагийг Монголдоо зохион байгуулдаг. Манай нийгэмлэгт хандсан төгсөгч залууст Жугамогийн гишүүд бид үргэлж нээлттэй. Төгсөгчид хоорондын харилцаа бэхжүүлэхээс гадна Монгол дахь Японд төгсөгчдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, хоёр орны харилцаанд тус нэмэр үзүүлэх зорилготой ажилладаг байгууллага.



З.Сугар







Япон дахь хамгийн дэлгэр МОНГОЛ НААДАМ - "ХАВРЫН БАЯР"

Япон дахь Монгол оюутны холбооноос жил бүр зохион байгуулдаг хамгийн том баяр бол яах аргагүй "ХАВРЫН БАЯР" билээ. Баярын тухай ЯМОХ-ны төгсөгч гишүүдийн дурсамжаас хуваалцлаа.

ЯМОХ-ны хамгийн том арга хэмжээ нь Хаврын баяр байдаг. Гоё санагдсан зүйл гэвэл тэр үеэр анх удаа монгол гэр барьсан. Хөдөө амьдарч, гэр барьдаг л байсан. Гэхдээ бие даагаад залуучууд гэр барихаар ханын толгой нийлүүлэхээс эхлээд асуудал их тулгардаг юм билээ. Харин барьж дуусаад өөрсдөөрөө маш их бахархах сэтгэгдэл төрсөн. Японы цэцэрлэгт хүрээлэнгийн зүлгэн дээр монгол гэрээ барьчихаад хононо гэдэг бол маш гайхалтай мэдрэмж байдаг.




Н.Бямбадорж




Д.Тэгшжаргал

ЯМОХ-ноос насны найзуудаа олсон гэж боддог. Хүний нутагт бие биенээ түшиж, уулзуулах, урам зориг, хөөр баяр өгөх цэг нь ЯМОХ байдаг. ЯМОХ-ны гишүүн байснаар олон арга хэмжээг зохион байгуулах ажилд оролцдог. Энэ нь эргээд ажлыг төлөвлөх, хуваарилах, хэрэгжүүлэх, хянах зэрэг сургуульд заадаггүй Япон стандартын ажлын зохион байгуулалтыг маш их сурдаг. Аливаа зүйлийг хийхэд санхүү хэрэгтэй болдог. Үүнийг босгох ажлыг төлөвлөх, өөрсдөө аян зохион байгуулан аж ахуй нэгж, байгууллагуудтай уулзалт зохион байгуулах, санхүүжилт бүрдүүлэх зэрэг ажил дээр гарахад хэрэгтэй олон зүйлсийг ЯМОХ-нд, ЯМОХ-г дэмжин ажилладаг Япон хүмүүсээс сурсан. Бас нэг том жишээ ярихад, "Хаврын баяр"-ын зохион байгуулалтын үеэр "Хог цэвэрлэгээ"-ний тусдаа баг гаргаж ач холбогдол өгч байсан нь одоо ч амьдрал дээр хог хаягдлын талаар баримтлах зарчмуудыг суулгаж өгсөн гэж боддог. ЯМОХ-ноос сурсан эдгээр зүйлс одоо ч амьдрал хэрэглэгдээд явж байгаа.



3х3 Сагсан бөмбөгийн тэмцээний үеэр



IGNITE (ажил хайлтыг дэмжих ивэнт ZOOM)

Монгол Улсыг Японд төлөөлөх хамгийн том байгууллага. 1996 онд хэсэг оюутан залуус санаа нэгдэн зохион байгуулалтад орж Япон дахь Монгол Оюутны Холбоо (ЯМОХ) гэдэг байгууллагыг өлгийдөж авснаар, өдгөө тэр нь оюутан төвтэй, үйл ажиллагаагаа тогтмол явуулдаг өнөр гэр бүл болоод байна.

"Дэм дэмэндээ, дээс эрчиндээ" гэдэг шиг хол газар, хүний нутагт бие биедээ харамгүй тусалж, дэмжлэг болж хамтдаа хичээж явах нь оюутан бидэнд хэрэгтэй. Энэ үндсэн чиг хандлагыг барин ЯМОХ нь Япон дахь Монгол Оюутнууд болон Монгол залуустаа чиглэсэн үйл ажиллагаа болон мэдээ мэдээлэл тогтмол хүргэдэг.

Үүнээс дурдвал Япон улсад ирээд удаагүй шинэ оюутнуудаа зориулан "Халуун Сэтгэл ТББ" –тай хамтарч "Yokoso in Japan", мэргэжил сонголтод чиглэсэн "Сэнпаи аа ольё", ажил хайлтыг дэмжих "IGNITE", "Спорт Наадам" болон давхардсан тоогоор 50 мянга гаруй хүн оролцдог хамгийн том эвэнт болох "Хаврын баяр"–ыг зохион байгуулдаг юм.

Мөн Япон–Монголын хамтарсан нийгэмлэг, сайн дурын байгууллага, Монголд элэгтэй япончууд, Монголын төрийн болон төрийн бус байгууллага, Японд төгсөгч монголчуудын "ЖУГАМО" нийгэмлэг мөн бусад оюутны байгууллагуудтай хамтран ажилладаг. 2020–2021 оны хувьд цаг үеийн байдалтай нийцүүлж түлхүү үйл ажиллагаа, сургалт семинарыг цахимаар явуулж байна.

Yamoh/Япон дахь Монгол Оюутны Холбоо/ЯМОХ/
在日モンゴル留学生会

yamoh.official

Yamoh/Япон дахь Монгол Оюутны Холбоо/ЯМОХ/
在日モンゴル留学生会

ЯПОН ЗОРИХЫН ӨМНӨХ ЗӨВЛӨГӨӨ



цахимаар

Япон дахь Монгол Оюутны Холбооны Тэргүүн
Нямдоржийн ЭРДЭНЭМАА

Япон улсыг зорин суралцах хүсэлтэй нийт залуучуудаа энэ өдрийн мэндийг хүргэе. Намайг Н.Эрдэнэмаа гэдэг. Япон улсад анх 2015 онд Японы Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрөөр ирж байсан. Одоогоор Токио хотын Цахилгаан Холбооны Их Сургууль (電気通信大学) –д мэдээллийн технологийн чиглэлээр суралцдаг. Япон улсыг зорин ирэх гэж байгаа оюутнуудаа доорх таван зүйлийг зөвлөж байна.

- *Япон улсад ирэхээсээ өмнө маш сайн судалгаа хийх. Үүнд амьдралын өртөг, амьдрах байр, утасны төлбөр, тээврийн зардал, ажил хийх боломж , хэлний сургуулийн жилийн хөтөлбөр зэрэг бүх зүйлийг нарийн судалснаар харь газар санхүүгийн асуудалд орох эрсдэлээс өөрийгөө хамгаалж чадна.*
- *Эрүүл мэндийн даатгал маш чухал. Япон улс нь бусад өндөр хөгжилтэй оронтой харьцуулахад маш бага үнэ (оюутан дунджаар сарын 1000 иен) төлөөд эмчилгээнийхээ 70 хувийг улсаас даалгадаг. Гадаад оронд ганцаараа гэртээ өвдөх нь хамгийн хэцүү зүйл байдаг тул ЭМД-д заавал хамрагдаарай.*
- *Японд ирээд эхний зургаан сар япон хэлэндээ хамаг анхаарлаа төвлөрүүлээрэй. Ямар ч хүн туушатай хичээх юм бол зургаан сарын хугацаанд N3 цаашлаад N2 ийн зэрэгтэй болж чадна. Би дөрөвдүгээр сард Хирагана ч мэдэхгүй ирээд 12 сард N2 т тэнцэж байсан. Хэрвээ эхний зургаан сардаа хэлээ сайн сурч чадвал цалин өндөртэй цагийн ажил хийх боломжоос эхлээд өөр бусад олон боломж нээгдэх болно.*
- *Сурах гэж ирсэн зорилгоо мартаж болохгүй. Японд ирсэн маш олон залуучууд амьдралын өндөр өртөг болон санхүүгийн асуудалтай тулгарч хичээлээ таслах, сургуулиа хаяж хар ажилчин болох тохиолдол цөөнгүй байдаг. Тийм учраас өдөр бүр ирсэн зорилгоо марталгүй хичээлээ нэгт тавиарай. Хэрвээ тэгж чадвал хэлний бэлтгэлээс их сургуульд дэвшин суралцах, сургуулийн тодорхойлолт авах, төрөл бүрийн төсөл хөтөлбөрт хамрагдах зэрэг маш олон боломж нээгдэх болно.*
- *Туушатай байгаарай. Бид бүгд өөр өөрсдийн гэсэн зорилгодоо тэмүүлэн арлын Япон орныг зорьдог. Япон орон бол хичээж байгаа хүн бүхэнд гадаад хүн гэж харалгүй маш олон боломжийг олгодог. Тийм учраас өөрийн ирсэн зорилгоо марталгүй туушатай байгаарай. Хичээж байгаа хүнд үргэлж аз тохиодог юм.*

ЯПОНЫ ТУХАЙ СТАТИСТИК МЭДЭЭ



Нийслэл **ТОКИО** (13.9 сая хүн амтай)

Нутаг дэвсгэр **377.975 км²**

Хүн амын тоо **126 сая**



Хүйсийн харьцаа **49% эрэгтэй 51% эмэгтэй**

Дундаж наслалт **79.5 эрэгтэй 86.4 эмэгтэй**



Гэрлэх дундаж нас **31.1 эрэгтэй 29.4 эмэгтэй**

Тэжээвэр амьтан **8.4 сая нохой 9.6 сая муур**

Нэг хүнд ноогдох ДНБ **41,634$**

Суурь боловсролтой **96%**

Эдийн засаг дэлхийд **III байр**

Дээд боловсролтой **46%**



ДЭЛХИЙД ТАНИГДСАН ЯПОН СОЁЛ

Цаг бариmтлах соёл



Япончууд цагийг чанд баримталж, товлосон цагаасаа таван минутын өмнө ирсэн байх ёстой гэсэн соёл байдаг.
Аливаа арга хэмжээ эхлэхээс таван минутын өмнө бэлэн байна гэсэн үг юм. Өдөр туттмын ажил сургуулиас авахуулаад, хурал цуглаан, тоглолт үзвэр зэрэг бүх зүйлд хамааралтай юм.

Галт тэргээр зорчих соёл



Галт тэрэг болон автобусан дотор гар утсаар ярих, чанга дуугаар ярихгүй байх. Утсаа чанга яригч дээр тавьж ярих болон чанга дуу хоолойгоор ярих нь галт тэрэг, автобусанд зорчиж буй хүмүүсийн тайван байдлыг алдагдуулна. Хэрэв та чимээ шуугиан гаргавал та асуудалд ч орж магадгүй.
Мөн та галт тэргэнд болон автобусанд явж байхдаа хоол идэх, нүүрээ будах зэрэг нь бусдад саад учруулах тул эдгээр зүйлийг хийхгүй байхыг зөвлөж байна.
Хүмүүсийн амьдарч буй газар болон олон хүн байгаа газарт та дүрэм, ёс журмыг дагаж мөрдөнө үү.

Хог ялгах соёл

Япон улсад хогийн сав тийм ч элбэг биш. Маш цэвэрхэн гэсэн яриаг хүн болгон мэдэх байх. Нэзрээ л хогийн сав, манай хоттой харьцуулахад маш цөөн байдаг. Бараг байдагүй гэсэн ч болохоор. Ихэвчлэн сүлжээ дэлгүүр болон зооснь машины хажууд байдаг. Тэрэнд юуч хамаагүй хийхгүй, гадна зааврын дагуу хогоо ангилж хийнэ. Таны хаях гэж байгаа хогны хогийн сав байхгүй бол гэртээ авч харина л гэсэн үг. Хогоо ангилж ялган хаяхаас гадна хог тус бүрийг өөр өөр өдөр хаядаг. Жишээ нь, шатдаг хогийг мягмар гарагт, хуванцар савны хогийг лхагва гарагт хаяна. Хог хаях өдөр нь хот, муждаа өөр өөр байдаг. Шилийг бас өнгөөр нь ангилж хаяна. Байрны гадаа хог хаях хэсгийг цэгцтэй байлгах, салхинаас сэргийлэх зорилгоор тороор хучсан байдаг. Шил ангилж хийх эвхэгддэг торон сав, сагсан сав ч бий.Шилээ өнгөөр нь ангилж хийнэ. Цагаан шилийг цагаанд, борыг борд, химийн бодисны шилийг цэнхэр саванд гэх мэтээр ангилна. Их дэлгүүрийн үүдэнд байрлах хогийн сав хуванцар сав – шатдаг – шатдагүй гэж ангилж хийдэг. Хог ялгах заавар, хаях өдрийн хуваарийг гадаадаас ирж буй шинэ оюутнуудад үзүүлэх сургалт зохион байгуулагддаг. Их сонирхолтой шүү.


2011 оны гуравдугаар сарын 11-нд газар хөдлөхөд (Цунами) тэр үеийн зохион байгуулалт, хүмүүсийн хандлага мундаг байсан нь сэтгэлд тод үлджээ. Атомын цахилгаан станцад дэлбэрэлт болсон ч хүмүүс ажиллассаар л байлаа. Эдийн засгийн эрэлтийг зогсоож болохгүй гэх үүднээс харилцагч нартаа өгсөн амлалтаа биелүүлэхийн төлөө тайван ажиллаж байсан тэр зан нь гайхалтай байв.



С.ЭНХБАЯР







Virtual цахим хаягууд Японд өргөнөөр дэлгэрээд байна. Заавал өөрийн нүүр царайг илтгэх бус анимэ, хиймэл моделийн дүрсүүдийг ашиглан олон сая дагагчтай дэлхийд нэр нь түгсэн топ цахим хуудсууд бий. Тэдгээрийн нэг нь Imma юм.

Imma бол нүүрний хэсгийг 3DCG-ээр үүсгэж, амьд үйл ажиллагаанд авсан биетэй нэгтгэдэг виртуал оршихуй юм. Нүүр царай, нэрээ хэлээгүй продюсер М, CG продакшн "Modeling Cafe" продюссерээр ажиллаж байна.

Imma бол ягаан боб стилийг үс засалтыг харуулсан Японы анхны виртуал загвар юм. Өндөр, жин, үндэс угсаа, гарал үүсэл гэх мэтийг огт мэдэхгүй. 2018 оны долоодугаар сараас Instagram хуудсаа нээж, загвар, соёл, нийгэмд хандсан мессежүүдийг байршуулсан. Одоогийн байдлаар 330.000 гаруй дагагчтай болжээ. Тэрээр олон загвар, гоо сайхны брэндүүдтэй хамтран ажиллаж байсан бөгөөд Японд төдийгүй гадаадад ч анхаарал татдаг. Мөн энэхүү нүүр царайг бүтээхэд 15.000 орчим хэмжээсийг ашиглаж бүтээдэг байна.

Эх сурвалж: www.instagram.com/imma.gram

Япон тогоочийн ЗААВРААР

ЯПОН ХООЛ ХИЙЖ СУРЦГААЯ!!

Япон хоол, япон соёлыг сурахыг хүсвэл доорх youtube сувагт нэгдээрэй. Элчин сайдын яамны тогооч Ихаратай хамт олон төрлийн Япон хоол хийж сурцгаая!!!



ЯПОН УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ SUBSCRIBE

- Шимизү тогоочийн олон төрлийн амтат Япон хоолыг Монголын олны танил эрхмүүдтэй хамт хийсэн сонирхолтой контентуудыг та бүхэн дараах сувгаас үзээрэй.



Chef Shimizu in Mongolia SUBSCRIBE

Анимэд дурлагсад



Анимэ нь Япон улсаас гаралтай бөгөөд дэлхийн олон оронд энэ төрлийн зураг ном, хүүхэлдэйн киног сая, сая үзэгч үзэж байна. Япон улсыг Анимэ, Мангагүйгээр төсөөлөхөд бэрх. Манай залуус ч япон анимэг хамгийн ихээр сонирхох болсон. "Би далайн дээрэмчдийн хаан болно" гэх үгийг өнөөдөр мэдэхгүй, сонсоогүй залуус тун цөөн бизээ. 2011 оноос хойш анимэ сонирхогчдын тоо өдрөөс өдөрт хурдацтай нэмэгдэж байна. Зарим телевизид албан ёсны эрхтэйгээр Анимэ суваг хүртэл нээж байна. Залуусын хамгийн хандалттай анимэ сошиал орчин бол яах аргагүй Анимакс билээ. Уг сайт япон анимэг монгол залуустаа сурталчилан таниулах, япон соёлыг түгээн дэлгэрүүлэхээр зүтгэж явна. Бусад сайтаар ялгарах гол зүйл нь тэд албан ёсны эрхтэйгээр цоо шинэ анимэг орчуулан гаргадаг. Хамгийн тод жишээ нь, Naruto The Last Movie /Монгол дахь нээлт/-ийг албан ёсны эрхтэйгээр үзэгчиддээ хүргэсэн юм.








Эх сурвалж: www.animax.mn

ОЛИМПТОЙ ХОСЛОСОН ТЕХНОЛОГИЙН ТАЙХАМШИГ

Зуны 32 дахь удаагийн Олимпын их наадам "Токио 2020", 2021 оны долоодугаар сард үзэгчгүйгээр зохион байгуулагдахаар тов гаралд байна. Дэлхийн өнцөг булан бүрт зураг ширтэн суух үзэгчдэд технологийн өндөр дэвшлийг ашиглан Олимпын их наадмыг яг дэргэдээс нь харах мэт сэтгэгдэл төрүүлэхээр япончууд ажиллаж байна. Ингээд Олимпын үеэр ашиглах зарим технологио сонирхуулъя.



Эх сурвалж: facesite.jp

3D хологрaмын шууд нэвтрүүлэг

Бодит орчинд 3D дүрс, үсгийг нэгтгэж, тусгай дэлгэцэнд хоёр хэмжээст дүрсээр нэвтрүүлнэ. Тамирчин нүдний өмнө тоглож байгаа мэт харагдах, тоглолт үзэх шинэ арга хэлбэр бол 3D хологрaмын шууд нэвтрүүлэг юм.

Автоматаар оноо тоолдог систем

Шүүгчдийн нүдээр харах боломжгүй градус, хэмжилтийг 3D лазерийн тусламжтайгаар нэг секундэд хоёр сая удаа тусгаж, тамирчны хөдөлгөөнийг гурван хэмжээст дүрст шилжүүлж оноо тоолох систем юм.

Нүүр таних систем

Дэлхийн электрон, компьютер, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн хамгийн том үйлдвэрлэгчдийн нэг Японы NEC компани зуны Олимп болон Паралимпаар нүүр таних технологийг ашиглахаар болжээ.

ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР



Оюутан залуус "Ханаби" галт наадмын үеэр

SCAN ME

Япон улсын Элчин сайдын яамны вэб хуудас

SCAN ME

Япон улсын Элчин сайдын яамны фэйсбүүк хуудас

Япон улсын Элчин сайдын яам

Хаяг: *Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Элчингийн гудамж-10, Япон улсын Элчин сайдын яам*

Утас: *11 320777*